



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



ХӨГЖЛИЙН ЭРХ ЗҮЙН ТӨВ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САНД ХИЙСЭН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны баг:

Төслийн удирдагч: Г.Эрдэнэбат, ХЭТ-ийн Удирдах зөвлөлийн дарга
Төслийн зохицуулагч: О.Мөнхцэцэг, ХЭТ-ийн Гүйцэтгэх захирал

Судлаачид:

Б.Отгон, ХЭТ-ийн судлаач
С.Халиун, ХЭТ-ийн судлаач
П.Намуун, ХЭТ-ийн судлаач

Хянан тохиолдуулсан:

П.Бадамрагчаа, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

Улаанбаатар хот
2022 он

ННА 67.3
ДАА 340.009
Ш-978



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САНД ХИЙСЭН
СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны баг:

Төслийн удирдагч: Г.Эрдэнэбат, ХЭТ-ийн Удирдах зөвлөлийн дарга
Төслийн зохицуулагч: О.Мөнхцэцэг, ХЭТ-ийн Гүйцэтгэх захирал

Судлаачид:

Б.Отгон, ХЭТ-ийн судлаач
С.Халиун, ХЭТ-ийн судлаач
П.Намуун, ХЭТ-ийн судлаач

Хянан тохиолдуулсан:

П.Бадамрагчаа, ННФ-ын Эрх зүйн хөтөлбөрийн менежер

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9840-1-4

© Нээлттэй Нийгэм Форум, 2022

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ТОВЬЁГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	4
УДИРТГАЛ	5
Нэг. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САН БУЮУ “SHUUKH.MN”-ИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН СУУРЬ ДҮН ШИНЖИЛГЭЭ	10
1.1. Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах эрх зүйн орчин	10
Хоёр. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САНД ШИЙДВЭР БАЙРШУУЛСАН БАЙДАЛ	15
2.1. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр	15
2.2. Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр	21
Гурав. ШҮҮХЭЭС ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРИЙГ ЦАХИМ САНД БАЙРШУУЛСАН БАЙДАЛ	35
3.1. Анхан шатны шүүхийн шийдвэр	35
3.2. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр	43
3.3. Хяналтын шатны шүүхийн шийдвэр	47
Дөрөв. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ	49
ДҮГНЭЛТ, САНАЛ	57
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	61
ХАВСРАЛТ	62

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АШШШТ	Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол
БГД	Баянгол дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ДЗШШ	Давж заалдах шатны шүүх
НДЗШШ	Нийслэлийн давж заалдах шатны шүүх
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
СБД	Сүхбаатар дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
УДШ	Улсын Дээд шүүх
ХЭТ	Хөгжлийн эрх зүйн төв
ЧД	Чингэлтэй дүүрэг
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШТ	Шийтгэх тогтоол
ШЦТ	Шийтгэх, цагаатгах тогтоол
ШШЦС	Шүүхийн шийдвэрийн цахим сан
ЭИХДЗШШ	Эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХАШШ	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

УДИРТГАЛ

Шүүх эрх мэдлийн салбарын ил тод байдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасан “Шударга шүүхээр шүүлгэх” эрхийг хангах үндсэн шалгуурын нэг юм. Энэхүү эрхийг хангах зорилгоор тасралтгүй хийгдэж буй шүүх эрх мэдлийн салбарын шинэтгэлийн нэг үр дүн нь “Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл” бөгөөд шүүхийн шийдвэрийг сонгон хэвлүүлж байгаа нь эдгээр судалгааны үр дүнг эргэлтэд оруулах, хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, шүүхийн нээлттэй байдлыг хангах, шүүхэд олон нийтийн хяналт тогтоох, эрх зүйн шүүмж судлал, үндэсний эрх зүйг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулж байна¹.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар² “Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна”, “Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаагаа олон нийтэд тогтмол мэдээлнэ” гэж тус тус заасны дагуу Монгол Улсын хэмжээнд шүүхээс хэрэг, маргаан хянан шийдвэрлэж буй ажиллагааг бүхэлд нь цахимжуулан шүүхийн шийдвэр нэг бүрийг олон нийтэд нээлттэй, ил тод, хүртээмжтэй байлгах зориулалт бүхий www.shuukh.mn цахим хуудас хэрэглээнд нэвтрээд багагүй хугацаа өнгөрч байна. Шүүхийн шийдвэр нь тухайн маргааныг хянан шийдвэрлүүлсэн талуудад хамаарах эрх зүйн акт байхын зэрэгцээ нөгөө талаас эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын нэн чухал хэрэглэгдэхүүн юм.

Энэ нь хууль зүйн салбарт хийгдсэн томоохон дэвшил хэдий ч нөгөө талаас шүүхийн шийдвэрийг нийтлэхдээ тухайн маргааны талуудын халдашгүй байх эрх, бусад хуулиар хамгаалагдсан эрхийг хөндөхгүй байх нь зүйтэй.

¹ Монгол Улсын Шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл, I боть, 2015 он.


² 2021 оны 1 дүгээр сарын 15-нд УИХ-аас баталсан Шүүхийн тухай хууль.

Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журмыг “Шүүхийн ерөнхий зөвлөл батална” гэснийг удирдлага болгон Шүүхийн ерөнхий зөвлөлийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А/44 тоот тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-аар энэхүү харилцааг зохицуулж байна.

Тус журамд “...Хэргийг тухайн шүүхийн Тамгын газрын даргын тушаалаар томилогдсон ажилтан буюу админ хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг хэргийн бүх оролцогчид гардаж авснаас хойш ажлын тав хоногт багтаан цахим санд байршуулах ба ингэхдээ шийдвэрт дурдсан иргэн, хуулийн этгээдийн регистр, бүртгэлийн дугаар болон хаягийг дарж, тэдгээрийн нэрийн зөвхөн эхний үсгийг үлдээж нийтлэх...”-ээр журамлажээ.

2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх нэг жилийн хугацаанд цахим санд байршуулсан хэргийн тоон мэдээг харвал эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 13,470 хэрэг шийдсэнээс 11,334, иргэний хэргийн анхан шатны шүүхээс 53,678 хэрэг шийдсэнээс 7,862, захиргааны хэргийн анхан шатны шүүхээс 1,524 хэрэг шийдсэнээс 865³ хэргийг (График 1-ийг харна уу.) цахим санд тус тус байршуулсан байна.

График 1. Шийдвэрлэсэн хэрэг, цахим санд байршуулсан шийдвэрийн тоо



³ Статистик мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан 2020 оны шүүн таслах ажиллагааны тайланд дурдсан тоон мэдээллийг shuukh.mn цахим сангийн мэдээлэлтэй харьцуулан гаргав.

Дээрх шийдсэн хэргийн тоог цахим санд байршуулсан шүүхийн шийдвэртэй харьцуулбал эрүүгийн хэргийн 84.2, иргэний хэргийн 14.7, захиргааны хэргийн 56,7 хувийг тус тус цахим санд байршуулж байгаа нь журамд дурдсан олон нийтэд ил тод, хүртээмжтэй, нээлттэй байх зорилгоо хангаж ажиллаж байгаа эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

Иймд бид энэхүү судалгаагаар шүүхийн шийдвэрийн цахим санд шийдвэр нийтлэх эрх зүйн зохицуулалт, ил тод байдал, эрх зүйн үндэс, цахим сан хэрэглэгчийн үнэлгээ зэргийг судалж, санал зөвлөмж боловсруулахыг зорилоо.

Дээрх зорилгын хүрээнд дараах асуудлыг хөндөх юм. Үүнд:

- Түүврийн аргаар сонгогдсон шүүхүүдийн 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөн оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаанд шийдсэн хэргийн шүүхийн шийдвэрийн хэдэн хувийг шүүхийн шийдвэрийн цахим санд нийтэлсэн;
- Шүүхийн шийдвэрийн цахим санд нийтэлсэн дээрх шийдвэрүүд нь хууль, журамд нийцсэн эсэх;
- Мөн дээр дурдсан хугацаанд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийдсэн Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэгт заасан “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”, Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-ийн шүүхийн шийдвэрүүдийг цахим санд хууль, журамд заасан шаардлагын дагуу нийтэлсэн эсэх;
- Шүүхийн шийдвэрийн цахим санг хэрэглэгчийн ойлголт, сэтгэгдэл, үнэлгээ зэргийг судлах зорилт тавилаа.

Монгол Улсын бүх шатны шүүх жилд 80,000 орчим хэрэг хянан шийдвэрлэдэг бөгөөд энэхүү судалгаагаар түүнийг бүхэлд нь судлах боломжгүй тул тодорхой шүүхийг түүвэрлэн сонголоо. Ингэхдээ дараах шалгуур, хүчин зүйлсэд анхаарсан болно. Үүнд:

2020 оны байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд нийт 13,470, давж заалдах шатны шүүхүүд 2,702, хяналтын шатны шүүх 685 хэрэг хянан шийдвэрлэсэн байна. Үүнээс газар орны байршлын хувьд дүүргийн шүүх, аймаг дахь сум дундын шүүх, сум дахь сум дундын

шүүхүүдээс тус бүр хоёр буюу нийт зургаан шүүхийн шийдвэрийг бүхэлд нь судлав. Шүүхийг сонгохдоо хамгийн олон болон хамгийн цөөн тооны хэрэг хянан шийдвэрлэсэн гэсэн шалгуураар сонгов. Өөрөөр хэлбэл, дүүргийн шүүхийн хувьд хамгийн олон буюу 2,064 хэрэг хянан шийдвэрлэсэн Баянзүрх дүүрэг дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, харьцангуй цөөн буюу 132 хэрэг шийдвэрлэсэн Багануур дүүрэг дэх Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийг сонголоо. Түүврийн аргаар сонгогдсон шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн хэргийг авч үзсэнийг Хүснэгт 1-д харуулав.⁴

Хүснэгт 1. Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо

№	Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	Хэргийн тоо		Өсөлт, бууралт	
		2019 он	2020 он	Тоо	Хувь
1	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	106	98	-8	-7.5
2	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	393	487	94	23.9
3	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	147	163	16	10.9
4	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	83	51	-32	-38.6
5	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1882	2064	182	9.7
6	Багахангай дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	119	132	13	11.0

⁴ Статистик мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс гаргасан 2020 оны шүүн таслах ажиллагааны тайланд дурдсан тоон мэдээллийг shuukh.mn цахим сангийн мэдээлэлтэй харьцуулан гаргав.

Эдгээр зургаан шүүхийн шийдвэрлэсэн хэрэг нийт 2,995 буюу тухайн тайлангийн хугацаанд анхан шатны шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн хэргийн 22.2 хувийг эзэлж байгаа нь эрүүгийн хэргийн нийт шүүхийн шийдвэрийг төлөөлүүлэх боломжтой гэж үзэж байна.

Харин давж заалдах болон хяналтын шатны шүүхийн хувьд дээрх зургаан шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргүүдээс давж заалдах гомдол гарган шийдвэрлэсэн магадлал, тогтоолыг судлан мониторинг хийх юм.

Гэсэн хэдий ч Эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүхийн шийдвэрийн цахим санд байршсан байдлыг судлахад түүврийн аргаар анхан шатны шүүхийн шийдвэрээс сонгогдсон 664 хэргийг хяналтын шатны шүүхээр шийдвэрлэсэн эсэх нь цахим сангаас үзэх боломжгүй байв. Учир нь цахим санд дээд шатны шүүхээр шийдвэрлэсэн хэргийн талаарх холбоос байхгүй тул судлах боломжгүй нөхцөл байдал үүссэн юм.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэгт заасан “Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд, мөн Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан “Авлигын гэмт хэрэг”-ийн шийдвэрүүдийг онцлон судаллаа. Учир нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоо жил ирэх тутам нэмэгдэж байгаа бөгөөд учрах хохирол нь их, авлигын хэргийн хувьд Эрүүгийн хуульд шинэ төрлийн хэрэг бөгөөд холбогдох шүүхийн шийдвэр нь судлаачдын дунд эрэлттэй, шүүхийн практикт жишиг тогтоогүй байна.

Судалгааны хүрээнд шүүхийн шийдвэрийн цахим сангийн үйл ажиллагаа, түүнийг хэрхэн хөгжүүлэх, тулгарч буй хүндрэл, бэрхшээлийг тодруулах зорилгоор цахим санд шийдвэр байршуулдаг албан хаагчидтай фокус бүлгийн ярилцлага хийх нь чухал гэж үзлээ.

Шүүхийн шийдвэрийн санг хэрэглэгчийн үнэлгээ, сэтгэгдэл, санал, зөвлөмжийг авах зорилгоор асуумж боловсруулан, анкетын аргаар тэдний санал хүсэлтийг авч нэгтгэн, судалгааны тайланд тусгаж Шүүхийн ерөнхий зөвлөлд санал болгон хүргүүлэх юм.

НЭГ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САН БУЮУ “SHUUKH.MN”-ИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН СУУРЬ ДҮН ШИНЖИЛГЭЭ

1.1. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙГ ЦАХИМ САНД БАЙРШУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Шүүхийн тухай хуулиар “Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна”, “Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаагаа олон нийтэд тогтмол мэдээлнэ” гэж тус тус заасан.

Улмаар Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Шүүхийн захиргааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.21г, 12.1.2, 15 дугаар зүйлийн 15.2, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн 2014 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр 32 тоот тогтоол баталж “Шүүхийн шийдвэрийг нийтлэх журам” баталжээ.

Харин Шүүхийн тухай хуулийн⁵ 8 дугаар зүйлийн 8.1, 8.6, Шүүхийн захиргааны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3.5, Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны дүрмийн 14.6 дахь заалтыг үндэслэн ШЕЗ-ийн ажлын албаны даргын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А/44 тоот тушаалаар “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах” журам баталжээ. Энэхүү хоёр журмаар шүүхийн шийдвэрийг цахим хэлбэрээр нийтэд хүргэж шүүхийн ил тод байдлыг хангах эрх зүйн үндэс бүрдэж байх тул эдгээр хэм хэмжээнд нарийн дүн шинжилгээ хийж хийдэл, дутагдлыг олж арилгах нь онцгой ач холбогдолтой гэж бид үзэв. Энэ судалгаанд цаашид 2014 оны 32 тоот журмыг “Нийтлэх журам”, 2017 оны оны А/44 тоот журмыг “Байршуулах журам” гэнэ.

⁵ Шүүхийн тухай хууль, 2002 он.

Эхний журмын зорилго нь “Шүүхийн шийдвэрийг олон нийтэд нээлттэй, ил тод болгож, олон нийтийн хяналт, судалгааны эргэлтэд оруулах”-д оршиж байна. Шүүхийн шийдвэрийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр нийтлэх талаар зааж, цахимаар нийтлэхтэй холбоотой зохицуулалтыг журмын гуравдугаар зүйлд дараах байдлаар тусгажээ. Үүнд:

“3.1. Хэрэг, маргааныг эцэслэн шийдвэрлэсэн анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрээс цахим сан бүрдэнэ.

3.2. Шүүхийн шийдвэрийн цахим сан үндсэн зохицуулагч (ШЕЗ-ийн ажлын албаны Мэдээллийн технологийн хэлтсийн дарга) болон дэд зохицуулагч (Шүүхийн Тамгын газрын мэдээллийн технологийн мэргэжилтэн)-тай байна.

3.3. Үндсэн зохицуулагч бусад дэд зохицуулагчийн хэрэглэгчийн нэр, нууц үгийг шинээр үүсгэх, өөрчлөх, цахим сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, хамгаалах, боловсронгуй болгох, хяналт тавих, дэд зохицуулагчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэгтэй.

3.4. Дэд зохицуулагч цахим санд шүүхийн шийдвэрийг шинээр оруулах, засварлах ажлыг гүйцэтгэнэ. Энэ үйл ажиллагаанд Тамгын газрын дарга өдөр тутам хяналт тавина.

3.5. Шүүгчийн туслах шүүхийн шийдвэрийг хэргийн бүх оролцогчид гардуулж өгснөөс хойш 24 цагийн дотор PDF эсвэл зурган файл хэлбэрээр дагалдах хуудасны хамт дэд зохицуулагчид хүлээлгэн өгнө. Шүүх тухайн хэрэг, маргааны онцлогоос шалтгаалж шүүх хуралдааныг хаалттай явуулсан бол шүүгчийн туслах шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг дагалдах хуудасны хамт дэд зохицуулагчид хүлээлгэн өгнө.

3.6. Дэд зохицуулагч шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах хэрэглэгчийн тусгай нэр, нууц үгтэй байна. Хэрэглэгчийн нэр, нууц үгийг бусдад дамжуулах, ашиглуулахыг хориглоно...” гэсэн зохицуулалт тус тус хийжээ.

Харин Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ)-ийн ажлын албаны даргын баталсан журмын 2.2 дугаар зүйлд “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах нь шүүхийн үйл ажиллагааг олон нийтэд ил тод, нээлттэй,

хүртээмжтэй байлгах, шүүгч, эрдэмтэн, багш, судлаач, шинжээч, хуульчдад судалгааны ажил хийх, оюутан сурагчдад гарын авлага болгох, судалгааны эргэлтэд оруулах зорилготой” хэмээн тодорхойлсон байна. Эдгээр журам нь шүүхийн тухай хуулийн үзэл баримтлал, шүүхийн ил тод байдлыг хангах зорилгод нийцэж байгаа бөгөөд бүхэлдээ цахим санд шүүхийн шийдвэрийг байршуулах, түүнд хяналт тавих гэсэн хоёр үндсэн процессыг зохицуулахад чиглэжээ.

Эдгээр процесс нь шүүхийн захиргааны дотоод үйл ажиллагааг журамласан шинжтэй хэм хэмжээ боловч түүгээр дамжуулан шүүхийн ил тод байдал, хувь хүний нууцыг хамгаалах, хүүхдийн эрх ашгийг хамгаалах зэрэг нийтийн эрх ашгийг хөндсөн үр дагавартай байна.

Тухайлбал, “Байршуулах журам”-ын 3.6-д “Цахим санд шүүхийн шийдвэрийг байршуулахдаа шийдвэрт дурдсан иргэн, хуулийн этгээдийн регистр, бүртгэлийн дугаар болон хаягийг устгаж, тэдгээрийн нэрийн зөвхөн эхний үсгийг үлдээнэ” гэж заасан нь хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахтай холбоотой олон үр дагавар дагуулж буйг тодорхой харуулж байна. Тус журмын 3.7, 3.8-д заасан шүүхийн шийдвэрийн зөвхөн тогтоох хэсгийг оруулахаар заасан нь ч дээрхийн адил ач холбогдолтой бөгөөд эдгээр заалтын хэрэгжилтийг бүрэн хангахад л шүүхийн ил тод байдлыг хангах явцдаа хувь хүний болон байгууллагын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, хувийн нууцыг хадгалах зорилтууд амжилттай хэрэгжих боломжтой болж байгаа билээ.

Дурдан буй хоёр журмын хэм хэмжээнд дүн шинжилгээ хийхэд дараах нөхцөл байдал тогтоогдов. “Нийтлэх журам”-д өдөр тутамдаа шүүхийн шийдвэрийг гардан оруулах дэд зохицуулагчийн асуудлыг нарийвчлан зохицуулахдаа уг ажилтан нь мэдээлэл, технологийн мэргэжилтэн байх ёстойг, зөвхөн уг мэргэжилтэн шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах эрхтэй байхыг шууд шаардсан зохицуулалт хийжээ. Гэтэл ШЕЗ-ийн ажлын албаны даргын баталсан журмаар уг хатуу стандартыг хөнгөвчилж тухайн шүүхийн Тамгын газрын даргын тушаалаар томилогдсон ажилтан хариуцан гүйцэтгэхээр заасан нь өдгөө практикт шүүгчийн туслах бүрд эрх олгож улмаар бүх шүүгчийн туслах өөрсдийн хариуцсан шүүгчийн шийдвэрийг цахим санд оруулж

хэвшжээ. Ингэснээр журмын 3.6, 3.7, 3.8-д заасан шаардлагыг хангахгүй буюу жигд бус, шүүхийн алдаатай олон шийдвэр цахим санд байршихад хүрсэн гэж үзнэ.

ШЕЗ хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд 2014 оны 32 тоот тогтоолоор шүүхийн шийдвэрийг цахим хэлбэрээр нийтлэх журмыг нэгэнт тогтоосоор байхад 2017 онд ШЕЗ-ийн ажлын албаны дарга тушаал гаргаж “Хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх” хэмээх тодорхой бус нөхцөлтэй хэм хэмжээг ашиглан дахин А/44 дугаартай журам гаргасан нь зүй ёсоор анхаарал татсан явдал юм. Журмуудын хэм хэмжээ болон хэрэгжилтээс үзэхэд “Нийтлэх журам” нь зохион байгуулалт, үйл ажиллагааны шинжтэй хэд хэдэн асуудлыг зохицуулаагүй орхигдуулсан хийдлийг арилгах зорилгоор “Байршуулах журам” баталсан байна. Тухайлбал, ШЕЗ-өөс баталсан “Нийтлэх журам”-ын 3.4, 3.5-д шүүхийн шийдвэрийг дэд зохицуулагч гэх албан тушаалтан шүүгчийн туслахаас хүлээн авч цахим санд оруулах, ингэхдээ хаалттай хуралдааныг дагалдах хуудасны хамт түүнд хүлээлгэж өгнө хэмээн ерөнхий байдлаар зохицуулаад орхисныг “Байршуулах журам”-аар дэд зохицуулагч болох “админ” нь:

- шүүхийн шийдвэрийг хүлээж авснаас хойш тав хоногийн дотор цахим санд байршуулах;
- байршуулахдаа иргэн, хуулийн этгээдийн регистр, бүртгэлийн дугаар болон хаягийг устгаж, тэдний нэрийн зөвхөн эхний үсгийг үлдээх;
- хаалттай хуралдааны шийдвэрийн зөвхөн тогтоох хэсгийг байршуулах;
- хүний захидал харилцаа, эрүүл мэнд, эд хөрөнгө, гэр бүлийн нууц байж болзошгүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогтой холбоотой технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээ, хууль ёсны ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй гэж үзсэн шийдвэрийг, мөн зөвхөн тогтоох хэсгийг байршуулах зэрэг нарийвчилсан зохицуулалт хийсэн нь ач холбогдолтой байна.

Харамсалтай нь уг үйл ажиллагаатай холбоотой хийдлийг арилгах явцдаа “Нийтлэх журам”-д заасан “Шүүхийн Тамгын газрын мэргэжилтэн буюу дэд зохицуулагч” гэх албан тушаалтныг “Байршуулах журам”-аар “Тамгын газрын даргын тушаалаар томилогдсон шүүхийн мэдээллийн технологийн мэргэжилтэн эсхүл бусад ажилтан болгон” өргөжүүлж мэдээллийн технологийн мэргэжлийн бус, хэд хэдэн хүн цахим санд мэдээлэл оруулахаар зохицуулсан нь олон алдаа дутагдлын эх сурвалж болсон гэж үзэж байна.

Түүнчлэн шүүхийн шийдвэрийг цахим санд “Нийтлэх”, “Байршуулах” журамд тодорхой зааж өгсөн хяналтын чиг үүргийг туйлын хангалтгүй хэрэгжүүлж байна. Шүүхийн шийдвэрийг цахим санд нийтлэх, байршуулахтай холбоотой илэрсэн алдаа дутагдал нь ихэвчлэн техникийн шинжтэй буюу шийдвэр байршуулсан ажилтан хайхрамжгүй хандсан эсхүл холбогдох журмуудыг мэдэхгүйгээс гарсан байх магадлалтай байтал эдгээр шийдвэрийг байршуулсан байдалд хяналт тавих үүрэгтэй Тамгын газрын дарга энэ бүхнийг хянаж, алдаа дутагдлыг засуулсан тохиолдол огт гараагүй байгаа юм.

ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САНД ШИЙДВЭР БАЙРШУУЛСАН БАЙДАЛ

2.1. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүдийн хувьд хамгийн олон болон хамгийн цөөн хэрэг хянан шийдвэрлэснээр шүүхүүдийг сонгон авч ажилласан болно. Жишээлбэл, дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн хувьд хамгийн олон хэрэг хянан шийдвэрлэсэн Баянзүрх дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, хамгийн цөөн хэрэг хянан шийдвэрлэсэн Багануур дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийг сонгон авч цахим санд байршуулсан хэргийн шийдвэрүүд дээр ажилласан болно.

Цахим санд байршуулсан шүүхийн шийдвэрийг шүүж үзсэн үр дүнг Хүснэгт 2-т харуулав.

Хүснэгт 2. Шийдвэрлэсэн хэргийн тоо болон түүвэрлэсэн шийдвэрийн тоон харьцуулалт

№	Шүүхийн нэр	Шийдвэрлэсэн хэргийн тоо	Цахим сангаас түүвэрлэн авсан хэргийн шийдвэрийн тоо
1	Багануур дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	132	103
2	Баянзүрх дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2064	332

Хүснэгт 2-ын үргэлжлэл

3	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	98	89
4	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	487	23
5	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	163	21
6	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	51	46

Дээрх анхан шатны зургаан шүүхийн шийдвэрийг түүвэрлэн авч нийт 614⁶ хэргийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ.

Нууцлалыг хангах хүрээнд хоёр бүлэгт хуваан нууцлал хэрхэн хангагдсан талаар судалж үзлээ. Хэргийн оролцогчид болох шүүгдэгч, хохирогч, гэрчийн нэр, хувь хүн, байгууллагын регистрийн дугаар, хаягийн нууцлалыг хэрхэн хангаж байршуулсан талаарх мэдээллийг Хүснэгт 3-аас харна уу.

⁶ Шүүхийн шийдвэрийн цахим сан shuukh.mn хуудаснаас судалсан нийт шийдвэрийн тоо болно.

Хүснэгт 3. Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчдын
мэдээллийн нууцлал хангагдсан байдал

№	Үзүүлэлт	Багануур ЭХАШШ		Говьсүмбэр ЭХАШШ		Сэлэнгэ Сайхан СДШ		Баянзүрх ЭХАШШ		Төв ЭХАШШ		Өмнөговь Ханбогд СДШ	
		Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
1	Шүүгдэгч	97	99.0	81	92.0	25	54.3	243	73.2	22	95.7	18	90.0
2	Хохирогч	94	95.9	85	96.6	7	15.2	63	19.0	9	39.1	2	10.0
3	Гэрч	91	92.9	84	95.5	0	0	31	9.3	6	26.1	0	0.0
4	Регист- рийн дугаар	67	68.4	25	28.4	4	8.7	287	86.4	20	87.0	20	100.0
5	Хаяг	56	57.1	15	17.0	1	2.17	212	63.9	10	43.5	14	70.0

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэн авсан 614 шийдвэрээс үзэхэд шүүгдэгчийн овог, нэрийн нууцлал 79.2, хохирогчийн овог, нэрийн нууцлал 42.3, гэрчийн овог, нэрийн нууцлал 34.5, хувь хүн, байгууллагын регистрийн дугаарын нууцлал 68.9, хувь хүн, байгууллагын хаягийн нууцлал 50.9 хувь тус тус хангагджээ. Шүүх тус бүрийн хэргийн оролцогчийн нууцлал хангагдсан байдал харилцан адилгүй байгааг дээрх хүснэгтээс харах боломжтой. Тухайлбал, Багануур дүүрэг дэх эрүүгийн хэргийн анхан шатны шүүх (ЭХАШШ)-ийн цахим санд байршуулсан шийдвэрийн 99.0 хувьд нь шүүгдэгчийн нууцлал хангагдсан байгаа бол Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх (СДШ)-ийн цахим санд байршуулсан шийдвэрийн 54.3 хувь нь шүүгдэгчийн овог, нэрийн нууцлалыг хангаж байршуулсан байна. Шүүгдэгчийн нэрийн нууцлал сонгон судалсан зургаан шүүхийн хувьд 54.3-99.0 хувь нууцлал хангагдаж байршуулжээ. Бусад мэдээллийн нууцлалтай харьцуулахад шүүгдэгчийн нэрийн нууцлал харьцангуй сайн хангагдаж байгаа ч шүүгдэгчийн нэр, хаяг, регистрийн дугаар нууцлаагүй, бүх зүйлийг нээлттэй байршуулсан тохиолдол гарсан байгааг дурдах нь зүйтэй.

Харин хохирогчийн нэрийн нууцлал маш хангалтгүй буюу хоёр шийдвэр тутмын нэгд нь л нууцлал хангагдаж байна. Сонгон түүвэрлэсэн анхан шатны зургаан шүүхийн хувьд Багануур дүүрэг дэх ЭХАШШ, Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх (СДЭХАШШ) тус тус цахим санд байршуулсан шийдвэрт хохирогчийн нууцлал 95-аас дээш хувьтай хангагдсан байна. Харин Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь СДШ, Баянзүрх дүүрэг дэх ЭХАШШ, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь СДШ-ийн цахим санд байршуулсан шийдвэрт хохирогчийн нэрийн нууцлал 20 хувьд хүрэхгүй байгаа нь маш хангалтгүй үзүүлэлт юм. Төв аймаг дахь СДЭХАШШ-ийн хувьд 39.1 хувийн үзүүлэлттэй гарчээ. Хохирогчийн нэрийн нууцлалыг цаашид онцгой анхаарах шаардлагатай байна. Жишээлбэл, онцгой содон нэртэй хүн болон гэмт хэрэг болсон газар орон, байршлаас хамааран нэрийн нууцлал хийгдээгүй шийдвэрийг уншсан хүн тухайн хүнийг ямар хэргийн хохирогчоор тогтоогдсоныг шууд мэдэх боломжтой болох юм.

Гэрчийн нууцлалын хувьд Багануур дүүрэг дэх ЭХАШШ, Говьсүмбэр аймаг дахь СДЭХАШШ тус тус 92-оос дээш хувь нууцлал хангасан

шийдвэрийг цахим санд байршуулсан байгаа бол Төв аймаг дахь СДЭХАШШ нууцлалыг 26.1 хувь, Баянзүрх дүүрэг дэх ЭХАШШ 9.3 хувь хангасан хэргийн шийдвэрийг цахим санд байршуулжээ. Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь СДШ-ийн цахим санд байршуулсан 46, Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 20 шийдвэрийг тус тус судалж үзэхэд гэрчийн нууцлал огт хангагдаагүй, тэг хувьтай дүн мэдээ гарсан нь онцгой анхаарах, маш хангалтгүй үзүүлэлт болж байна.

Хувь хүн, байгууллагын регистрийн дугаарын нууцлал хэрхэн хангагдсан талаар судалж үзэхэд Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь СДШ 100, төв аймаг дахь СДЭХАШШ-ийн байршуулсан шийдвэрийн 87.0, Баянзүрх дүүрэг дэх ЭХАШШ-ийн байршуулсан шийдвэрийн 86.4, Багануур дүүрэг дэх ЭХАШШ 68.4 хувь тус тус нууцлал хангаж цахим санд байршуулсан байна. Говьсүмбэр аймаг дахь СДЭХАШШ 28.4 хувь хангасан шийдвэр байршуулсан нь дөрвөн хэрэг тутмын нэг нь нууцлал хангагдаж, бусад нь хангагдахгүй байна. Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь СДШ 8.7 хувь нууцлал хангасан шийдвэр байршуулсан байх бөгөөд 11 хэрэг тутмын нэг шийдвэрт нууцлал хангагдаж бусад шийдвэрт нууцлал хангагдахгүй байршуулсан нь маш хангалтгүй үзүүлэлт юм.

Хувь хүн, байгууллагын хаягийн нууцлал хэрхэн хангагдсан талаар судалж үзэхэд Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь СДШ-ийн цахим санд байршуулсан шийдвэрийн нууцлал 70.0 хувь, Баянзүрх дүүрэг дэх ЭХАШШ-ийн нууцлал хангасан шийдвэр 63.9 хувьтай байгаа нь хамгийн өндөр дүн болов. Төв аймаг дахь СДЭХАШШ-ийн цахим санд байршуулсан шийдвэрийн нууцлал 43.5 хувь, Говьсүмбэр аймаг дахь СДЭХАШШ-ийн цахим санд байршуулсан шийдвэрийн нууцлал 17.0 хувь, Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь СДШ-ийн цахим санд байршуулсан шийдвэрийн нууцлал 2.17 хувь гарсан нь маш хангалтгүй үзүүлэлт байна.

Бусад асуудлаар буюу хэргийн шийдвэрийг байршуулахдаа форматын алдаатай оруулсан эсэх, тухайн хэргийн шийдвэрийг зөв оруулсан эсэх, зүйл, хэсэг, заалтыг зөв оруулсан эсэх болон алдаатай бичсэн талаар мөн судалж дүнг Хүснэгт 4-т харуулав.

Хүснэгт 4. Бусад асуудлаар нууцлал хангагдсан байдал

№	Утга	Багануур		Говьсүмбэр		Сэлэнгэ		Баянзүрх		Төв		Өмнөговь	
		ЭХАШШ	хувь	ЭХАШШ	хувь	Сайхан	хувь	ЭХАШШ	хувь	ЭХАШШ	хувь	Ханбогд	хувь
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	Формат алдаатай эсэх	1	1.0	0	0	0	0	1	1.4	2	8.7	0	0
2	Тухайн хэргийн шийтгэх (цагаатгах) тогтоол мөн эсэх	97	94.2	87	98.9	46	100	331	99.6	0	0	20	100
3	Зүйл, хэсэг алдаатай эсэх	25	24.3	23	26.1	9	19.6	10	3.1	6	26.1	2	10
4	Огноо, дугаар дараалаагүй	19	18.4	3	3.4	5	10.9			1	4.3	1	5
5	Алдаатай бичсэн	5	4.9	11	12.5	9	19.6	10	3.3	7	30.4	2	10

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүвэрлэн авсан 614 шийдвэрээс үзэхэд формат алдаатай дөрвөн шийдвэр, зүйл, хэсэг алдаатай 75 шийдвэр оруулсан байна. Баянзүрх дүүргийн ЭХАШШ-ийн хувьд огноо, дугаарын дарааллыг шалгаагүй бөгөөд бусад сонгон авсан таван шүүх дээр судалж үзэхэд 29 шийдвэр дараалал алдаатай, 44 шийдвэр үг үсгийн болон техникийн алдаатай бичигдсэн зэрэг алдаа зөрчил гарсан байна.

2.2. ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхүүдийн хянан шийдвэрлэсэн хэргийн тоог цахим санд байршуулсан хэргийн тоотой харьцуулан үзэхэд Говьсүмбэр аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх 88.8 хувь, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 98.5 хувьтай, давж заалдах шатны бусад шүүх 100 хувь цахим санд шийдвэрээ байршуулсан сайшаалтай дүн гарсан байна. Хянан шийдвэрлэсэн хэргийн болон бусад ажиллагааны хувьд хамгийн бага дүнтэй Говьсүмбэр аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх шийдвэрээ бүрэн байршуулаагүй байгаа нь доорх хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 5. Хянан шийдвэрлэсэн хэрэг, байршуулсан шийдвэрийн тоо, хувь

№	Шүүхийн нэр	Хянан шийдвэрлэсэн хэргийн тоо ⁷	Цахим санд байршуулсан шийдвэрийн тоо ⁸	Хувь
1	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	1508	1485	98.5%

⁷ ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны тайлан, 2020 он.

⁸ Shuukh.mn-д байршуулсан шийдвэрийн тоо, 2021 он.

Хүснэгт 5-ын үргэлжлэл

2	Говьсүмбэр аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	27	24	88.8%
3	Өмнөговь аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	78	78	100%
4	Төв аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	63	63	100%
5	Сэлэнгэ аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх	80	80	100%

Харин ачааллын хувьд нийслэлийн есөн дүүргийн хэргийг хүлээн авч хянан шийдвэрлэдэг хамгийн их ачаалалтай ажиллаж байгаа Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх 1,508 хэрэг хянан шийдвэрлэснээс 1,485 хэргийн шийдвэрийг цахим санд байршуулсныг харахад тухайн шүүхийн Тамгын газрын удирдлага, зохион байгуулалт, хариуцлагатай хандаж байгааг илтгэж байна гэж судалгааны багийн зүгээс үзлээ.

Говьсүмбэр аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

2020 оны бүтэн жилийн тайлан мэдээллээр 27 хэрэг шийдвэрлэсэн гэж мэдээлсэн⁹ байна. Шүүхийн шийдвэрийн цахим сан (ШШЦС)-д байршуулсан тухайн шүүхийн шийтгэх тогтоолоос харвал уг магадлалын дугаар авах ажиллагаанд 24 хүртэлх дугаар авагджээ. Тооны зөрүүнээс харахад нийтлэгдээгүй магадлал гарахаар байна.

⁹ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/849 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан.

Энэхүү судалгааны тайлангийн гуравдугаар бүлэгт судлагдах Эрүүгийн хууль (ЭХ)-ийн 12 болон 22 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт хамаарах магадлал хоёр байна. Иймд 24 магадлалаас өөр бүлэгт судлагдах хоёр магадлалыг хасаж, үлдэх 22 магадлалыг энэ хэсэгт авч үзлээ.

Хүснэгт 6. Магадлалын дугаар

№	Алдаа дутагдал	Магадлалын тоо	Магадлалын дугаар
1	Зүйл, хэсэг бүртгээгүй	8	16, 17, 18, 19, 20, 21, 22, 23

Нийтлэгдсэн 22 тогтоолын хувьд авч үзвэл:

1. Найм буюу 36.3 хувь нь зүйл, хэсэг бүртгээгүй буюу зүйл, хэсгийг сонголгүйгээр нийтэлсэн алдаа дутагдал гаргасан;
2. 22 магадлалаас хоёр нь хаалттай буюу тогтоох хэсгээс бусад хэсэг нийтлэгдэхээргүй байна. Гэтэл тогтоох хэсгийг нийтлээгүй, зөвхөн нууцлалтай гэсэн тэмдэглэгээг цахим санд оруулсан;
3. Шүүгдэгч, гэрч, хохирогчийн нэрийг нууцлах ажиллагаа бүх магадлалын хувьд алдаа дутагдалгүй хийгдсэн байгаа ч регистрийн дугаарын нууцлал нэг, хаягийн нууцлал хоёр магадлалд тус тус хийгдээгүй;
4. 22 магадлалын хүрээнд бусад алдаа дутагдлыг судлан үзэхэд зүйл, хэсэг бүртгээгүй найман магадлал, анхан шатны шүүх (АШШ)-ийн №63 дугаартай тогтоолыг хянасан гэж магадлалдаа дурдсан давж заалдах шатны шүүх (ДЗШШ)-ийн №05, №22 дугаартай хоёр магадлал гарсан байна. Магадлалыг цахим санд нийтлэхдээ зүйл, хэсгийг бүртгэхгүй байгаа алдаа дутагдал нь анхан шатны шүүхээс гадна давж заалдах шатны шүүхэд мөн гарч байна. Харин ДЗШШ-ийн магадлалуудад АШШ-ийн №63 дугаартай тогтоолыг хянасан тухай магадлал яагаад хоёр байгааг, эрүүгийн хэргийн дугаарын мэдээлэл тухайн тохиолдолд яагаад хоёр өөр байгааг зөвхөн цахим

санд байршуулсан эдгээр мэдээллийн хүрээгээр тайлбарлах боломжгүй. Ямар боловч хоёр өөр хэрэгт нэг дугаар өгөгдсөн үү эсвэл аль нэг шатны шүүх нь шийдвэрийнхээ мэдээллийг цахим санд зөрүүтэй бүртгэсэн үү гэсэн асуудал хөндөгдөж байна. Тус шүүхийн байршуулсан 22 магадлалаас 14-ийнх нь хувьд АШШ-ээс цахим санд байршуулсан тогтоол нь олдож, тухайн хэрэгт гарсан магадлал мөн байна гэдэг нь тодорхой мэдэгдэж байгаа бол найман магадлалын хувьд хэргийн дугаар зөрж байгаа эсвэл хэрэгсэхгүй болгосон захирамжийг хянасан магадлал тул тогтоол нь цахим санд нийтлэгдээгүй байна.

Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх

2020 оны бүтэн жилийн тайлан, мэдээллээр 1,508 хэрэг шийдвэрлэсэн¹⁰ байна. Шүүхийн цахим санд тус шүүхийн 1485 дугаартай тогтоол нийтлэгдсэн байгаагаас харвал 01-1485 дугаартай магадлалууд гарчээ. Үүнээс дугаарын дарааллаар хөөвөл дараах шийтгэх тогтоолууд цахим санд нийтлэгдээгүй¹¹ байна.

Хүснэгт 7. Нийтлэгдээгүй тогтоолын дугаар

№	Дугаарын интервал	Нийтлэгдээгүй тогтоолын тоо	Нийтлэгдээгүй шийтгэх тогтоолын дугаар
1	1-300 хүртэл	12	21, 23, 63, 64, 65, 139, 150, 165, 176, 181, 197, 253
2	301-500 хүртэл	3	390, 480, 481
3	501-800 хүртэл	9	507, 547, 551, 605, 640, 667, 704, 711, 764
4	801-1100 хүртэл	7	832, 906, 954, 1010, 1088, 1089, 1100

¹⁰ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/849 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан.

¹¹ Цахим сангаас 2021 оны 8 дугаар сарын 15-ны өдөр шүүлт хийж үзэхэд нийт 295 шийтгэх тогтоол нийтлэгдсэн байв.

Хүснэгт 7-гийн үргэлжлэл

5	1101-1300 хүртэл	38	1107, 1108, 1109, 1110, 1111, 1112, 1113, 1125, 1126, 1198, 1211, 1212, 1213, 1214, 1215, 1229, 1230, 1231, 1232, 1236, 1237, 1238, 1239, 1240, 1263, 1264, 1265, 1266, 1267, 1268, 1269, 1291, 1292, 1293, 1294, 1295, 1296, 1297
6	1301-1485 хүртэл	63	1303, 1310, 1334, 1338, 1339, 1342, 1352, 1365, 1368, 1369, 1370, 1379, 1380, 1381, 1382, 1383, 1385, 1386, 1387, 1388, 1395, 1396, 1397, 1398, 1399, 1414, 1419, 1420, 1425-1430, 1433-1434, 1441-1446, 1453- 1461, 1471-1484

Судалгааны дүнгээр нийт 132 магадлал нийтлэгдээгүй байна. Энэ нь тухайн шүүхийн 1485 хүртэл дугаар олгогдсон магадлалын есөн хувь нь нийтлэгдээгүй гэсэн үг юм.

Судалгааны ажлын аргачлалд дурдсанаар Багануур болон Баянзүрх дүүргийн ЭХАШШ-ийн шийтгэх тогтоолыг давж заалдах журмаар хянасан магадлалыг сонгон авч судлахаар төлөвлөсөн ч Нийслэлийн давж заалдах шатны шүүх (НДЗШШ)-ийн магадлалыг цахим санд нийтлэхдээ нийслэлийн хэмжээн дэх анхан шатны аль шүүхийн шийдвэрийг хянаснаар нь хайлт хийх болон магадлалыг ялгаж тусад нь харах боломжгүй, түлхүүр үгээр, тухайлбал, “Багануур” гэсэн хайлт хийхэд 1,485 магадлал дотроос тухайн дүүрэгт хамаарах магадлалыг тусад нь ялгаж харуулж чадахгүй байна. Иймд НДЗШШ-ийн магадлалыг судалгаанд дурдсан анхан шатны хоёр шүүхийн хэмжээнд анхан шат болон давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хооронд нь холбон судалгаа хийх боломжгүй байна.

Цахим санд байршуулсан нийт 1,485 магадлалын жагсаалтаас харахад дараах алдаа дутагдал ажиглагдлаа.

Хүснэгт 8. Алдаатай магадлалын дугаар

№	Алдаа дутагдал	Магадлалын дугаар
1	2 удаа нийтлэгдсэн	33, 191, 300, 301 (3 удаа), 449, 523, 627, 630, 638, 642, 677, 682, 862, 1025, 1098
2	Зүйл, хэсэг бүртгээгүй	Нийт 332 (ширхэг) магадлал
2.1	1-1200 хүртэл	1, 271, 301, 433, 581, 851, 1025, 1034-1042, 1047-1051, 1053-1086, 1092-1099, 1101-1106, 1116, 1119, 1122-1124, 1127-1197, 1199, 1200
2.2	1201-1309 хүртэл	1201-1210, 1216-1228, 1233-1235, 1241-1262, 1270-1290, 1298-1309
2.3	1310-1399 хүртэл	1311-1337, 1340, 1341, 1343, 1344, 1348-1351, 1353-1364, 1366, 1367, 1372-1378, 1384, 1389, 1390-1394
2.4	1400-1485 хүртэл	1400-1402, 1404-1413, 1415-1418, 1421-1424, 1431, 1432, 1435-1440, 1447-1452, 1461-1463, 1468, 1469, 1470

Цахим сан дахь дугаарын жагсаалтаас харахад хоёр удаа нийтлэгдсэн магадлал 14, гурван удаа нийтлэгдсэн магадлал нэг байна. ЭХ-ийн зүйл, хэсгийг сонгохгүйгээр байршуулсан магадлал нийтлэгдсэн нийт магадлалын 22.3 хувийг эзэлж байгаа нь анхаарал татаж байна.

БЗД-ийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс сонгон авсан 332 тогтоолоос 37 нь Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр хянагджээ.¹² Эдгээр 37 шийдвэрийг хэргийн дугаар, зүйл ангиар хайлт хийж үзэхэд найман шийдвэр байршуулсан ба бусад 29 шийдвэрийг оруулаагүй байв.

¹² Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхээр 2020 оны бүтэн жилийн байдлаар хянан шийдвэрлэсэн хэргийн жагсаалттай тулгаж харсан болно. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхтэй холбогдон хэргийн дугаараар тулгасан тулгалт бөгөөд ямар нэгэн албан бичиг байхгүй болно.

Хүснэгт 9. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн хянан шийдвэрлэсэн хэргийн жагсаалт (сонгон авсан 332 хэргийн шийдвэрээс хайлт хийсэн)

№	Зүйл анги	Давж заалдах шатны шүүх	
		Тогтоолын огноо, дугаар	Хэргийн дугаар
1	ЭХ 10.1.2.1, 10.2.6, 10.1.2.7, 10.1.2.8, 11.4.2, 11.6.1	2020.07.08 2020/ШЦТ/1274	1920 00305 0016
2	ЭХ 10.1.2.1, 10.1.2.7, 10.1.2.11, 11.2.1.2.1, 12.1.2.2, 17.1.2.1, 17.2.1, 11.6.1	2020.05.14 № 900	1906 00000 1263
3	ЭХ 11.6.2, 10.1.2.7	2020.04.15 2020/ШТ/689	1906 02297 0833
4	ЭХ 10.1.2.7	2020.04.14 №680	1906 05250 1922
5	ЭХ 10.1.2.7, 10.1.2.11	2020.03.24 2020/ШЦТ/492	1906 00000 1865
6	ЭХ 10.1.2.1, 10.1.2.2, 10.1.2.6, 10.1.2.7, 17.1.1, 17.2.2.1, 17.2.2.4, 17.3.1, 17.8.1	2020.01.30 2020/ШЦТ/173	1906 00418 0121
7	ЭХ 10.1.2.1, 10.1.2.8 11.6.2	2020.01.28 №151	1906060972235
8	ЭХ 15.1.2	2020.02.12 2020/ШЦТ/244	1906 04213 2263
9	ЭХ.5.3 20.7.2.2	2020.06.23 №1165	1802 00517 0285
10	ЭХ 17.1.1, 17.4.1, 18.6.1	2020.04.20 2020/ШЦТ/718	1906 06797 0535
11	ЭХ 17.3.3.1, 26.1	2020.09.25 2020/ШЦТ/1705	1909 02759 0141

Хүснэгт 9-ийн үргэлжлэл




12	ЭХ 17.1.1	2020.09.04 2020/ШЦТ/1611	2006 01391 1159
13	ЭХ 11.6.2 21.2.1	2020.02.19 2020/ШЦТ/291	1906 05707 2172
14	ЭХ 23.5.2	2020.02.19 №292	1806 08097 0419
15	ЭХ 24.3.1	2020.06.22 2020/ШЦТ/1152	2016 25012 640
16	ЭХ 24.3.1	2020.04.23 №749	1902 00866 0374
17	ЭХ 27.10.3	2020.07.10 2020/ШЦТ/1291	2003 00222 0181
18	ЭХ 11.6.1	2020.08.18 №1511	2006 00000 1940
19	ЭХ 11.6.1	2020.08.11 №1472	2006 01373 0585
20	ЭХ 11.6.1	2020.07.31 №1412	1818 00522 0517
21	ЭХ 11.6.2	2020.07.28 №1381	1906 00514 0302
22	ЭХ 11.6.1	2020.07.23 №1349	1906 03512 2774
23	ЭХ 11.6.1	2020.07.21 №734	1906 05992 2701
24	ЭХ 11.4.2.1	2020.07.08 №1274	1920 00305 0016
25	ЭХ 11.6.1	2020.07.07 №1266	2006 00000 0910

Хүснэгт 9-ийн үргэлжлэл

26	ЭХ 11.6.1	2020.07.03 №1229	2006 00000 0939
27	ЭХ 11.6.1	2020.06.29 №1183	1906 02120 0593
28	ЭХ 11.6.1	2020.06.04 №1056	1906 04439 1971
29	ЭХ 11.6.1	2020.06.02 №1023	2006 00539 0404
30	ЭХ 11.6.1	2020.08.17 №1504	1906 00156 1463

НЭХДЗШШ-ийн хайлтаар гарч ирсэн нэг хэргийн хувьд БЗД-ийн ЭХАШШ-ийн 2020 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн №151 дугаартай шийтгэх тогтоолоор шийдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 10.1 дүгээр зүйлийн 10.1.2.1, 10.1.2.8 дахь хэсэг, 11.6 дугаар зүйлийн 11.6.2 дахь хэсэгт зааснаар хаалттайгаар шийдвэрлэсэн хэрэг байв. Шүүхийн шийдвэр цахим санд байршуулах журмын 3.9 дүгээр зүйлд зааснаар “хаалттайгаар хянан шийдвэрлэсэн тохиолдолд тогтоолын тогтоох хэсгийг байршуулж, нууцлалыг хийх ёстой” гэж заасан ба анхан шатны шүүх цахим санд тогтоолыг байршуулахдаа уг заалтыг зөрчин удиртгал болон тодорхойлох хэсгийг бүхэлд нь оруулж харин тогтоох хэсгийг оруулаагүй, мөн алдаатай байршуулсан байв. Цахим санд байршуулсан өөр нэг хэргийн хувьд энэ хэрэг нь нууцлалтай тул тухайн шүүхийн Тамгын газарт хандана уу гэсэн байна (Зураг 1.).

Зураг 1. Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 54 дугаартай магадлал

 МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САН		Нүүр	Шийдвэр ▾	Шүүх хуралдаан	Иргэн танд ▾	Шүүхүүд	Холбоо барих
Шийдвэрийн мэдээлэл		  «Буцах»					
Шүүх	Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх	Магадлал нууцалсан тул тухайн шүүхийн Тамгын газартай холбогдоно уу.					
Шүүгч	Мөнхөөгийн Пүрэвсүрэн						
Хэргийн индекс	1906060972235						
Дугаар	2021/ДШМ/54						
Огноо	2021-01-07						
Зүйл хэсэг	10.1.2.1						
Улсын яллагч	Ц.Гантулгабат						

Харин давж заалдах шатны шүүхийн долоон шийдвэрийг хянаж үзэхэд анхан шатны шүүхийн шийдвэртэй адил шүүгдэгчийн овог нэрийг кодлоогүй нэг, хохирогч болон гэрчийн овог нэрийг кодлоогүй хоёр, байгууллагын нэр, байршлыг нууцлаагүй нэг, шүүгдэгчийн регистрийн дугаарыг нууцлаагүй нэг, шүүгдэгчийн гэрийн хаягийг нууцлаагүй нэг, шүүгдэгчийн өмнө нь эдэлж байсан ял шийтгэлийг дурдсан хоёр, бусад хувийн мэдээллийг нууцлаагүй хоёр, шүүхийн шийдвэрийн тогтоох хэсгийг нийтлээгүй нэг магадлал зэрэг алдаа гаргасан байсан бөгөөд долоон шийдвэрээс нэгийг л “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-д нийцүүлэн зохих нууцлалын дагуу байршуулсан байна.

Тогтоол бүрэн нийтлэгдсэн байдлыг шалгахад шүүхийн шийдвэрийн цахим сангаас олдсон дээрх холбогдох долоон шийдвэрийн зургаа нь бүрэн нийтлэгдсэн, нэг шийдвэрийн тогтоох хэсгийг дутуу байршуулсан байна. Формат алдаатай эсэх буюу үсгийн фонт системд танигдсан эсэхийг шалгахад бүгд алдаагүй нийтлэгдсэн байна. Зүйл, хэсэг сонгосон эсэхийг шалгахад нийт долоон шийдвэрийн зургаад нь зүйл, хэсэг зөв сонгосон байх ба үлдсэн нэг шийдвэрийн тогтоох хэсгийг буюу зүйл, заалттай хэсгийг нийтлээгүй байна.

Нийтлэгдсэн эсэхийг шалгахад долоон шийдвэрийн нэгд “Нийтлэх” журмын 3.6-д заасны дагуу товчлол хийгдсэн байх ба үлдсэн зургаан шийдвэр нь журамд нийцээгүй, хангалтгүй байдлаар нийтлэгджээ.

Давж заалдах шатны дээрх 30 хэргээс хяналтын шатны шүүхээр шийдвэрлүүлсэн нэг хэргийн шийдвэр олдсон бөгөөд тус шүүхийн шийдвэрийг хянаж үзэхэд шүүгдэгчийн овог нэрийг кодлоогүй шүүхийн шийдвэрийн төгсгөл хэсэгт бүтэн нэрээр нь бичсэн, мөн хохирогчийн овог нэрийг кодлоогүй, шүүгдэгч, хохирогчийн гэрийн хаягийг нууцлаагүй, бусад хувийн мэдээллийг илээр нийтэлжээ. Формат алдаатай эсэхийг шалгахад үсгийн фонг системд танигдсан, тогтоол бүрэн нийтлэгдсэн, давж заалдах болон анхан шатны шүүхийн шийдвэр цахим санд нийтлэгдсэн хэдий ч анхан, давж заалдах шатны шүүхийн шийдвэртэйгээ холбох холбоос үүсээгүй байгаа нь хэрэглэгчдэд хүндрэл учруулж байна.

Хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн хэргийн хувьд мөн давж заалдах шатны шүүхээр хянагдсан дээрх 37 хэргийн дугаараар хайлт хийн хэрэг хянагдсан эсэхийг тогтоосон болно. Цахим сангийн “хэргийн дугаар” хэсэгт тухай бүр хэргийн дугаарыг оруулан хайсан боловч хайлтын үр дүн олдоогүй. Иймээс эдгээр хэрэг хяналтын шатны шүүхээр хянан шийдвэрлэгдээгүй эсхүл хянагдсан боловч цахим санд байршуулаагүй байна гэж үзэхээр байна.

Өмнөговь аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

2020 оны бүтэн жилийн тайлан мэдээллээр 78 хэрэг шийдвэрлэсэн гэж мэдээлжээ¹³. Цахим санд байршуулсан тухайн шүүхийн шийтгэх тогтоолоос харвал уг магадлалын дугаар 78 хүртэл авагдсан байх тул нийт хянан шийдвэрлэсэн хэргийн магадлал бүгд нийтлэгдсэн байна.

¹³ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/849 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан.

Хүснэгт 10. Өмнөговь (Магадлалын дугаар)

№	Алдаа дутагдал	Магадлалын тоо	Магадлалын дугаар
1	Зүйл, хэсэг бүртгээгүй	24	1, 30, 48-69, 72
2	Огноо, дугаар дараалаагүй	1	54

Зүйл, хэсэг бүртгээгүй алдаа 24 магадлалд гарсан нь энэ шүүхийн 2020 онд гаргасан нийт магадлалын 31 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт юм. Огноо, дугаар нь дарааллаараа биш нэг магадлал байсан нь нь 54 дугаартай байв. Огнооны дарааллаар энэ магадлалын өмнөх магадлал болох 53 нь 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр, харин дараагийнх буюу 55-62 нь 9 дүгээр сарын 16-30-ны хооронд гарсан байх тул 54 дугаартай магадлал огнооны дарааллаар дугаараа аваагүй болох нь тодорхой байна.

Тус шүүх аймгийнхаа нутаг дэвсгэрт байрлах анхан шатны хоёр өөр шүүхийн тогтоолыг хянах бөгөөд цахим санд эдгээр анхан шатны шүүхийн төрлөөр магадлал нь тусдаа хайлт хийгдэхгүй тул Ханбогдын шүүхийн тогтоолыг хянасан магадлалуудыг тусад нь ялган¹⁴ судлахад хүндрэлтэй нөхцөл үүссэн. Хэд хэдэн шүүхийн тогтоолыг хянаж буй давж заалдах шатны шүүхийн магадлал, дээд шүүхийн тогтоолыг тухайн доод шатны шүүхийнх нь төрлөөр ялгаж судлах боломжтойгоор шүүхийн шийдвэрийн цахим сан (ШШЦС)-гийн үйл ажиллагааг боловсронгуй болгосноор уг сан нь шат шатны шүүх хоорондын “холбоотой шийдвэр”-ийн мэдээллийг хэрэглэгчид үнэн зөв өгөх нөхцөл бүрдэх юм.

¹⁴ Сэлэнгэ аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалыг судалгааны багийн зүгээс нэг бүрчлэн шүүж, зөвхөн Сайхан сум дахь сум дундын шүүхийн магадлалыг ялган, нарийвчилж судлахад хугацаа нэлээд зарцуулж байсан.

Сэлэнгэ аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

2020 оны бүтэн жилийн тайлан мэдээллээр 80 хэрэг шийдвэрлэсэн гэж мэдээлсэн¹⁵ байна. Цахим санд байршуулсан тухайн шүүхийн шийтгэх тогтоолоос харвал уг магадлалын дугаар 80 хүртэл авагдсан байна. Тооны хувьд зөрүүгүй байх бөгөөд эдгээр 80 магадлал нь Сэлэнгэ аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Сүхбаатар, Сайхан, Мандал сумдад байрлах анхан шатны гурван шүүхийн шийтгэх тогтоолыг давж заалдах шатны шүүхээс хянасан нийт дүн юм.

Хүснэгт 11. Сэлэнгэ (Магадлалын дугаар)

№	Алдаа дутагдал	Шийтгэх тогтоолын дугаар, тайлбар
1	Нийтлэгдээгүй	14, 22, 23, 66
2	2 удаа нийтлэгдсэн	65

Цахим санд 65 дугаартай магадлал 11 дүгээр сарын 10, мөн 11 дүгээр сарын сарын 3-нд хоёр удаа нийтлэгдсэн байв. Энэ шүүхийн хувьд бусад шүүхэд гарсан “зүйл, хэсэг бүртгээгүй” гэх алдаа гараагүй нь сайшаалтай юм. Давж заалдах шатны шүүхээс анхан шатны гурван шүүхийн ажлыг хянаж байгаа ч зүйл, хэсэг бүртгэх алдаа гаргаагүй байв. Үүгээрээ энэ төрлийн алдааг гаргахгүйгээр цахим санд шийдвэр нийтлэх бололцоо нийт шүүхэд байгааг харуулж байна.

Сайхан сум дахь шүүхийн 2020 онд шийдвэрлэсэн эрүүгийн хэргийн шийтгэх тогтоолыг давж заалдах шатны шүүхээс хянасан магадлалыг шүүхэд долоон магадлал гарч байна. Үүнээс энэхүү судалгааны тайлангийн өөр бүлэгт судлагдах ЭХ-ийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэрэгт хамаарах магадлал нэг байна. Иймд үлдэх зургаан магадлалыг энд авч үзлээ.

Байршуулсан зургаан магадлал бүгд нээлттэй шийдвэрлэсэн хэргийнх байх тул бүрэн хэмжээнд нийтлэгдсэн эсэхийг шалгахад энэ шаардлага

¹⁵ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/849 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан.

хангагдсан байна. Мөн шүүгдэгч, гэрч, хохирогчийн нэрийг нууцлах ажиллагаа зөв хийгдсэн ба алдаа дутагдалгүй байна.

Төв аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх

2020 оны бүтэн жилийн тайлан мэдээллээр 63 хэрэг шийдвэрлэсэн гэж мэдээлжээ¹⁶. Цахим санд байршуулсан тухайн шүүхийн магадлалын дугаар 63 хүртэл авагдсан бөгөөд тооны хувьд зөрүүгүй байна.

Дугаарын дарааллыг харвал 58 дугаартай магадлал нийтлэгдээгүй байна. Харин огноо, дугаар дараалаагүй, зүйл, хэсэг бүртгээгүй зэрэг нийтлэг алдаа ШШЦС-гийн шийдвэрийн жагсаалтаас харагдахгүй байна.

АШШ-ийн хэмжээнд түүвэрлэн судалсан 23 шийтгэх тогтоолын хүрээнд тус аймгийн ДЗШШ-ээс гарсан магадлалыг цахим сангаас шүүж үзэхэд нэг магадлал¹⁷ гарчээ. Энэхүү магадлал дахь нууцлал болон нийтлэх үйл ажиллагаатай холбоотой бусад алдааг судалж үзэхэд шүүгдэгч, гэрч, хохирогчийн нэрийн нууцлал хийгдээгүй, мөн регистрийн дугаар нууцлагдаагүй алдаа дутагдлууд гарав. Аль шүүх байх, хэдэн хэрэг шийдвэрлэх, судалгаанд хэдэн шийдвэр, магадлал сонгон авч судлахаас үл хамааран алдаа дутагдал тохиолдох магадлал өндөр, тэдгээрийн агуулга давхардсан, нийтлэг шинжтэй болох нь тодорхой байна.

¹⁶ Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/849 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан.

¹⁷ Төв аймаг дахь эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны шүүх. 2020 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн №43 дугаар магадлал.

ГУРАВ. ШҮҮХЭЭС ХЯНАН ШИЙДВЭРЛЭСЭН ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШИЙДВЭРИЙГ ЦАХИМ САНД БАЙРШУУЛСАН БАЙДАЛ

Судалгааны энэ хэсэгт Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 22 дугаар бүлэгт заасан Авлигын гэмт хэргийн шийдвэрийг анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхээс цахим санд байршуулж буй үйл ажиллагаанд мониторинг хийлээ. Ингэхдээ дараах асуудлын хүрээнд дүн шинжилгээ хийхээр судалгааны хүрээг тогтоов. Үүнд:

- Холбогдох шүүхийн шийдвэрийг зохих хугацааны дотор цахим санд бүрэн байршуулсан эсэхийг шүүн таслах ажиллагааны албан ёсны статистик мэдээлэлтэй харьцуулан шинжлэх;
- Цахим санд байршуулсан шүүхийн шийдвэр тус бүр алдаа зөрчилгүй нийтлэгдсэн эсэхийг Шүүхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг, “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-д тус тус заасны дагуу хаалттайгаас бусад шүүхийн шийдвэрийг бүрэн нийтлэх, нууцлалыг хангах шаардлага хангагдсан эсэх болон шүүхийн шийдвэрийн формал алдаа зөрчлийг давхар шалгав.

3.1. АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Шүүн таслах ажиллагааны статистик мэдээллээс Монгол Улсын хэмжээнд зарим төрлийн гэмт хэрэг шийдвэрлэсэн нийт тоог харах боломжтой ч аль орон нутагт буюу аль шүүхэд ямар зүйл, заалтын дагуу хэчнээн хэрэг хянан шийдвэрлэгдсэн талаарх нарийвчилсан тоон мэдээг шууд харах албан ёсны мэдээллийн нээлттэй эх сурвалж байхгүй байсаар байна. Судалгааны багийн зүгээс ШЕЗ-ийн статистикийн задгай мэдээллээс Эрүүгийн хуулийн 12, 22

дугаар бүлэгт заасан гэмт хэргийн тоон мэдээг шүүж нэгтгэсэн ба шүүн таслах ажиллагааны 2020 оны бүтэн жилийн тайлан мэдээнээс харахад Монгол Улсын хэмжээнд бэлгийн эрх чөлөөний эсрэг 369 гэмт хэрэг хянан шийдвэрлэгдсэн байна. Харин шүүхийн шийдвэрийн цахим санд энэ төрлийн 256 шийдвэр байршуулжээ. Статистикаас харахад авлигын 116 гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдсэн гэж мэдээлсэн байх боловч цахим санд 82 шийдвэр л байршуулсан байна. Холбогдох хууль, журамд зааснаар гэмт хэргийг нээлттэй, хаалттай горимоор хянан шийдвэрлэсэн эсэхээс хамааран шийтгэх тогтоолыг бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шийдвэр тус бүрийг олон нийтэд мэдээлэх, цахим санд байршуулах зохицуулалттай. Гэтэл бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 113 шийдвэр буюу 30 хувь, авлигын гэмт хэргийн 34 шийдвэр буюу мөн 30 хувь нь тус тус огт мэдээлэгдээгүй, нийтлэгдээгүй байна. Энэ талаарх мэдээллийг Хавсралт 1-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Шүүхийн статистикийн мэдээ гаргах тайлант хугацааны эхлэл, төгсгөл нь хуанлийн хугацаанаас долоо орчим хоногийн зөрүүтэй байдаг ч үргэлжлэх хугацаа адил тул шийтгэх 113 тогтоол буюу нийт шийдвэрийн 30 хувийг цахим санд нийтлээгүй шалтгаан нөхцөлийг ердөө долоо хоногийн зөрүүгээр тайлбарлах боломжгүй юм. Нөгөө талаас ШЕЗ-өөс баталсан “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-ын 3.4-т “Админ хэргийн бүх оролцогчид хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг гардаж авснаас хойш ажлын тав хоногт багтааж цахим санд байршуулах ажлыг хариуцна” гэж заасан. Гэтэл 2021 оны 8 дугаар сард цахим сангаас шийдвэр татаж унших ажиллагаа хийгдсэн буюу судалгааны туршид 2020 оны шүүхийн бүх шийдвэр нийтлэгдэх хугацаа бүрэн өнгөрсөн байсан. Өөрөөр хэлбэл, шүүхээс Эрүүгийн хуулийн 12, 22 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийг хууль, журмын дагуу нийтлэх үүргээ хангалтгүй биелүүлсэн байна.

Шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулсан “бэлгийн эрх чөлөөний халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг”-ийн 153 шийдвэр¹⁸, “авлигын гэмт хэрэг”-ийн 82 шийдвэр¹⁹-ийг уншиж судаллаа.

Цахим санд байршуулсан бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шийдвэрийн хүрээнд нийтлэгдээгүй 113 шийдвэр, үндэслэл шалтгаан дурдалгүйгээр шийтгэх тогтоолыг бүхэлд нь нууцалсан хоёр, зүйл хэсгийн автомат хайлтын илэрцэд гарч ирээгүй шийдвэр нэг, бүлгийн дугаар андуурч нийтэлсэн шийдвэр нэг тохиолдол тус тус гарлаа. Энэ талаарх мэдээллийг Хавсралт 1-ээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Харин цахим санд байршуулсан авлигын гэмт хэргийн шийдвэрийн хүрээнд нийтлэгдээгүй шийтгэх 34 тогтоол, үндэслэл шалтгаан дурдалгүйгээр бүхэлд нь нууцалсан шийдвэр гурав, бүлгийн дугаар андуурч нийтэлсэн шийдвэр нэг тохиолдол тус тус гарлаа. Энэ талаарх мэдээллийг Хавсралт 2-оос дэлгэрүүлэн харах боломжтой.

Дээрх нөхцөл байдлуудын улмаас шүүхийн шийдвэрийн цахим санд бодитоор нийтлэгдсэн бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн 147, авлигын гэмт хэргийн 78 шийдвэрийн хүрээнд эдгээр шийдвэр хууль, журамд заасны дагуу бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар нийтлэгдсэн эсэх, шүүхийн шийдвэрт дурдагдаж буй хувь хүн, байгууллагын нууцлалыг хангасан эсэх асуудлуудад дүн шинжилгээ хийлээ.

А. Хаалттай шүүхийн шийдвэрийг цахим санд нийтлэхэд гарч буй алдаа зөрчил

Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шийдвэрүүдэд тэмдэглэснээр 130 хэргийг хаалттай, 17 хэргийг нээлттэй шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэжээ. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хаалттай явуулсан бол ЭХХШТХ-ийн 36.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, Шүүхийн

¹⁸ Судалгааны үр дүнд төдийлөн нөлөөлөхгүй тул цаг хугацааг хэмнэн нийслэл дэх 9 дүүргийн ЭХАШШ-ийн цахим санд байршуулсан шийдвэрийг бүрэн, харин орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй шүүх тус бүрээс санамсаргүй түүврийн аргаар 1-4 шийдвэр сонгон судалсан. Энэ нь цахим санд байршуулсан энэ төрлийн шийдвэрийн 60 хувь юм.

¹⁹ Цахим санд нийтлэгдсэн авлигын гэмт хэргийн шийдвэрийг 100 хувь уншиж судалсан болно.

шийдвэрийг цахим санд байршуулах тухай журмын 3.7, 3.9-д тус тус заасны дагуу шийтгэх тогтоолыг тусгай хавтсанд хийх, зөвхөн тогтоох хэсгийг холбогдох товчлол хийн нийтлэх зохицуулалттай. Тэгвэл хаалттай шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн 130 тохиолдлын ердөө шийтгэх 20 тогтоол нь зөвхөн тогтоох хэсгийг, шийтгэх 122 тогтоол нь удиртгал, тодорхойлох, тогтоох хэсгийг нийтэд нь хамруулан бүрэн нийтлэгдсэн байгаа нь холбогдох хууль, журмыг зөрчсөн байна. Зөвхөн удиртгал, тодорхойлох хэсгийг хамруулан байршуулсан тогтоол тав байх бөгөөд хууль, журмын дагуу шийтгэх тогтоолыг ийм байдлаар нийтлэхийг зөвшөөрсөн зохицуулалт байхгүй юм.

Харин авлигын гэмт хэргийн шийдвэрүүдэд тэмдэглэснээр нэг хэргийг хаалттай, 77 хэргийг нээлттэй шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэжээ. Гэсэн атлаа хаалттай шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэгдсэн нэг шийтгэх тогтоолыг ердийн журмаар бүрэн нийтэлсэн нь хууль, журмыг зөрчсөн байна. Гурван шийдвэр зөвхөн удиртгал, тодорхойлох хэсгийг хамруулан тогтоох хэсэггүй нийтлэгдсэн бол бусад 74 шийтгэх тогтоол нь цахим санд алдаа зөрчилгүй байршсан байна.

Б. Нууцлал хангах хүрээнд гарч буй алдаа зөрчил

Бэлгийн гэмт хэргийн шийдвэрийн хүрээнд хэргийн оролцогчдын хувийн мэдээллийг хэрхэн нууцалсан байдлыг Хүснэгт 12-т харуулав.

Хүснэгт 12. Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчдын мэдээллийн нууцлал хангагдсан байдал

№	Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	Нийт шийтгэх тогтоол		Нууцлаагүй		
		тоо	хувь	тоо	хувь	
1	Нэр, овог	Шүүгдэгч	147	100	29	19.7
		Хохирогч	147	100	62	42.2
		Гэрч	147	100	69	46.9

Хүснэгт 12-ын үргэлжлэл

2	Хувь хүн, байгууллагын регистрийн нууцлал	147	147	16	10.9
3	Хувь хүн, байгууллагын хаягийн нууцлал	147	147	54	36.7

Шүүгдэгчийн нэрийг нууцлаагүй 20 тохиолдол нь шүүгдэгчийн биеийн байцаалт хэсэгт овог, нэрийн нууцлал хийсэн боловч бусад этгээдийн мэдүүлэг болон тогтоолын зарим хэсэгт нууцлалыг алдагдуулсан хайхрамжгүй алдаа гаргасан бол есөн шийтгэх тогтоолд овог, нэрийн нууцлал огт хийгээгүй илэрхий алдаа байв.

Дээрх хүснэгтийн мэдээллээс харахад шүүхээс шүүхийн шийдвэрийг байршуулах явцад шүүгдэгчийн овог, нэр, хувь хүний регистрийн дугаарын нууцлалыг харьцангуй өндөр хувьтай гүйцэтгэжээ. Регистрийн дугаар бол хувь хүнийг шууд тодорхойлох боломжтой дахин давтагдашгүй цорын ганц бүртгэл юм. Регистрийн дугаарыг нууцлаагүй тохиолдлын 12 нь шүүгдэгчийн, нэг нь асрамжийн асуудлыг шийдвэрлэх явцад шүүгдэгчийн хүүхдийн, гурав нь хохирогчийн регистрийн бүртгэл нийтлэгдсэн байв.

Харин гэрчийн тухайд 78 тогтоолд овог, нэрийн нууцлалыг хийсэн бол 69-д нь нууцлалгүй бүрэн бичиж байршуулсан байв. Гэрчийн нууцлалыг бараг 50:50 хувьд хуваагдахаар хоёр өөр янзаар гүйцэтгэснийг харахад энэ талаар нийт шүүх нэгдсэн ойлголтгүй байгааг харуулж байна.

Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн хохирогчийн хувьд манай нийгмийн соёл, хандлагаас шалтгаалан хохирогч болсноо бусдад мэдэгдэх хүсэлгүй ба хэргийн талаарх болж өнгөрсөн таагүй нөхцөл байдал дэлгэрэнгүй дүрслэн хэлэлцэгдэх нөхцөл үүсэх, эрүүл мэндийн байдалтай холбоотой мэдээлэл нийтлэгдэх эрсдэл бий. Холбогдох хууль, журмын хүрээнд хохирогчийн овог, нэр, мэдээллийг нууцлах үүрэгтэй атал шүүхээс байршуулсан шийтгэх тогтоолын 42.2 хувьд энэхүү журам зөрчигдсэн байна. Өөрөөр

хэлбэл, энэ тохиолдолд шүүхийн зүгээс албаны шугамаар олж авсан хувь хүний нууцыг хадгалах үүргээ биелүүлээгүй гэж үзнэ.

Хувь хүн, байгууллагын хаягийн нууцлалыг хангах байдал 54 шийтгэх тогтоол буюу 36.7 хувьд алдагдсан байна. Ихэнх тохиолдолд шүүгдэгчийн байнгын болон түр оршин суух хаягийг байршуулсан ба зарим тохиолдолд хэрэг болсон газрыг дурдах явцад хохирогчийн гэрийн хаяг нийтлэгдсэн байв. Энэ нь хохирогчийн хувьд гэмт хэргийн улмаас хохирсны дараа нийгэм, хүрээлэн буй орчноосоо тав тухгүй байдал мэдрэх зэргээр давхар хохирох үр дагавартай.

Авлигын гэмт хэргийн шийдвэрийн хүрээнд хэргийн оролцогчдын хувийн мэдээллийг нууцалсан байдлыг Хүснэгт 13-г харуулав.

Хүснэгт 13. Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчдын мэдээллийн нууцлал хангагдсан байдал

№	Авлигын гэмт хэрэг	Нийт шийтгэх тогтоол		Нууцлаагүй		
		тоо	хувь	тоо	хувь	
1	Нэр, овог	Шүүгдэгч	78	100	16	20.5
		Хохирогч	78	100	78	100
		Гэрч	78	100	46	59.0
2	Хувь хүн, байгууллагын регистрийн нууцлал	78	100	12	15.4	
3	Хувь хүн, байгууллагын хаягийн нууцлал	78	100	28	35.9	

Шүүгдэгчийн нэрийг нууцлаагүй 15 тохиолдлыг авч үзэхэд шүүгдэгчийн биеийн байцаалт хэсэгт нууцлал хийсэн боловч бусад этгээдийн мэдүүлэг болон тогтоолын зарим хэсэгт нууцлалыг алдагдуулсан хайхрамжгүй алдаа гаргасан байх бөгөөд шийтгэх нэг тогтоолд овог, нэрийн нууцлал огт хийгээгүй илэрхий алдаа гаргасан байв.

Регистрийн дугаар нууцлаагүй 10 тохиолдлыг авч үзэхэд хоёр зөрчил илэрсэн бөгөөд шүүгдэгчдийн нэг нь хахууль өгөгч байгууллагын нэр, регистрийг нөгөөх нь шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт хохирогчийн регистрийн дугаарыг тус тус нийтэлсэн явдал байна.

Авлигын гэмт хэргийн бүх шийтгэх тогтоолд хохирогчийн нэрийг нууцлалгүй бүтэн бичиж байршуулсан нь сонирхол татна. Журамд шийдвэрлэж буй гэмт хэргийн онцлог шинжүүдээс хамаарсан ялгамжтай зохицуулалт байхгүй тул хохирогч байгууллагын нэр, түүнийг төлөөлөн оролцож буй хувь хүний нэрийг бүтнээр бичиж оруулсан нь бүхэлдээ алдаа зөрчилд тооцогдох юм. Гэхдээ авлигын гэмт хэргийн хор уршиг нь төрд итгэх олон нийтийн итгэл буурахад нөлөөлөх бөгөөд дийлэнх тохиолдолд шууд хохирогч нь төрийн байгууллага байдаг. Иргэдээс шилжүүлсэн эрх мэдлийг хууль бусаар ашиглах, иргэдээс төвлөрүүлсэн татвараас бүрдэж буй төсвийн хөрөнгийг хууль бусаар зарцуулах үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрдэг онцлог гэмт хэрэг тул хохирогч төрийн байгууллагыг иргэд, олон нийтээс нууцлах нь өөрөө олон асуулт дагуулна. Ийм учраас энэ төрлийн гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн шийтгэх тогтоолд хохирогч төрийн байгууллагын нэр, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэрийг нууцлалгүй бүрэн нийтэлснийг зөрчилд тооцох нь эргэлзээтэй.

Харин гэрчийн тухайд 32 тогтоолд овог, нэрийг нууцалсан боловч 46-д нь нууцлалгүй бүрэн бичиж байршуулжээ. Энэ нь гэрчийн нууцлалыг хадгалах шаардлагатай эсэх асуудалд шүүхийн нэг мөр практик тогтоогүй байгааг харуулах биз ээ.

Хувь хүн, байгууллагын хаягийн нууцлалыг хангах байдал 28 шийтгэх тогтоолд буюу 35.9 хувьд алдагдсан байна. Хувь хүний гэрийн хаягийг байршуулсан бүх тохиолдолд шүүгдэгчийн хаяг байв.

В. Бусад формал алдаа зөрчил

Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн шийдвэрүүдийн хүрээнд судалгаанд ашиглагдах боломжгүй түвшний форматын ноцтой алдаа дутагдал илрээгүй. СХД-ийн ЭХАШШ-ийн 856 дугаар шийтгэх тогтоолын тогтоох хэсэг дуусаагүй буюу гол хэсэгт тухайн хэргийг

хянан шийдвэрлэсэн шүүгчийн нэр бичигдсэн байсан бол ЧД-ийн ЭХАШШ-ийн 168 дугаар шийтгэх тогтоол нь шууд “тогтоох нь” хэмээн тогтоох хэсгээр эхэлсэн атлаа олон мөр зай авсны дараа шүүхийн шийдвэрийг бүрэн байршуулсан байв. Харин ХУД-ийн ЭХАШШ-ийн 471 дүгээр шийтгэх тогтоолын бичвэр нь мөр хоорондын зай стандартаас их, зарим хэсэгтээ А4 хэмжээтэй цаасны тал хүртэлх хэмжээнд хоосон зай орхин бичигдсэн байсан бол Сүхбаатар аймаг дахь сум дундын ЭХАШШ-ийн 227 дугаар шийтгэх тогтоолд цөөн тооны үгийн үсгийн фонт нь танигдахгүй зэрэг бага зэргийн алдаа дутагдал илрэв.

“Зүйл, хэсэг алдаатай эсэх” агуулгын хүрээнд шүүхийн шийдвэрийн мэдээлэл хэсэгт бичигдсэн зүйл, хэсгийн дугаарлалт шийтгэх тогтоолд огт дурдагдаагүй буюу зөрүүлж бичсэн алдаа дутагдлууд гарсан байна²⁰.

Авлигын гэмт хэргийн шийдвэрийн хүрээнд СБД-ийн ЭХАШШ-ийн тогтоолын²¹ тогтоох хэсэгт шүүгдэгчид оногдуулсан 15,000 нэгжээр торгох ялыг 10,000 нэгж гэж андуурч бичсэн. Мөн тус шүүхийн хуралдаанаар дан ганц хахууль өгөх гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн атлаа тодорхойлох хэсэгт хахууль авсан хүнийг яллагдагч статусаар дурдаж нэрийг нь бүрэн бичиж байршуулсан байв²². ЧД-ийн ЭХАШШ-ийн тогтоолд²³ эрүүгийн хэргийн дугаарт үсэг нэмж бичсэн байсан бол БГД-ийн ЭХАШШ-ийн тогтоолд²⁴ мэдүүлэг хэсэгт шаардлагагүй үгийг од тэмдгээр тэмдэглэн нууцалсан нь тогтоолын агуулга, найруулгыг алдагдуулсан байна.

“Зүйл, хэсэг алдаатай эсэх” агуулгын хүрээнд шүүхийн шийдвэрийн мэдээлэл хэсэгт бичигдсэн зүйл, хэсгийн дугаарлалт шийтгэх тогтоолд огт дурдагдаагүй буюу зөрүүлж бичсэн алдаа дутагдлыг хамааруулан

²⁰ Багануур дүүргийн ЭХАШШ-ийн №2, ЧД-ийн ЭХАШШ-ийн №424, БЗД-ийн ЭХАШШ-ийн №505, Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүхийн №84 шийтгэх тогтоол.

²¹ 2020.04.28-ны №401 тогтоол.

²² 2020.04.17-ны №358 тогтоол.

²³ 2020.07.28-ны №616 тогтоол.

²⁴ 2020.12.30-ны №2021/ШЦТ/1, “...Намайг буруутгах зүйл*** гэж бодож байна. БИ 197 дугаар цэцэрлэгийг цэцэрлэгийн дайтай л цэцэрлэг болгосон. ...197 дугаар цэцэрлэг дээр 2018 оны 9 дүгээр сард очиж өргөдөл өгөхөд Х эрхлэгч орон тоо *** 10 дугаар сард шилжилт хөдөлгөөн гардаг, ...” гэх мэт шаардлагагүй хэсгийг нууцлан мэдээлсэн.

тооцов. БГД-ийн ЭХАШШ-ийн тогтоолд²⁵ ЭХ-ийн 23 дугаар бүлэгт заасан гэмт хэрэг хянан шийдвэрлэснийг шүүхийн шийдвэрийн мэдээлэл хэсэгт 22 дугаар бүлэгт тодорхойлсон зүйл, хэсгийн дагуу бичсэн алдаа гарчээ. Мөн Булган аймгийн сум дундын ЭХАШШ-ийн шийтгэх тогтоол²⁶ нь 22 дугаар бүлгийн 22.8.1.1-д тодорхойлсон гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байтал шүүхийн шийдвэрийн мэдээлэл хэсэгт 21.1.1 гэж бичсэн алдаа гарсан байна.

3.2. ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Эрүүгийн хуулийн 12, 22 дугаар бүлэгт тодорхойлсон гэмт хэргийн шийдвэрлэлтийг давж заалдах шатны шүүхээс хянан шийдвэрлэж магадлал гаргадаг билээ. Шүүхийн эдгээр магадлалыг шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулж буй байдал, байршуулахад гарч буй алдаа дутагдлын талаар энэ хэсэгт судаллаа.

Монгол Улсын хэмжээнд давж заалдах шатны шүүхээс гэмт хэргийн төрөл тус бүрээр шийдвэрлэсэн хэргийн тоо, нийт шүүхийн хүрээнд эсхүл шүүх тус бүрээр аль ч утгаар албан ёсны статистик мэдээлэл авах мэдээллийн нээлттэй эх сурвалж байхгүй байна. Ийм учраас цахим санд нийтлэгдсэн магадлалын тоо бүрэн эсэхэд үнэлэлт дүгнэлт хийх боломжгүй байв.

Цахим санд 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31 хүртэлх буюу нэг жилийн хугацаанд бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн 170 магадлал байршуулснаас 97 нь бүхэлдээ нууцлагдсан байсны дээр Баянхонгор аймгийн ДЗШШ таван магадлалыг хоосон байршуулсан байв. Увс, Ховд аймгийн ДЗШШ-ээс нэг магадлал²⁷ давтан байршуулсан зөрчил ч илэрсэн юм. Харин авлигын гэмт хэргийн 63 магадлалыг цахим санд байршуулснаас нэгийг бүхэлд нь нууцалсан байна.

²⁵ 2020.06.29-ний №640 тогтоол.

²⁶ 2020.06.15-ны №135 тогтоол.

²⁷ Увс аймгийн ЭИХДЗШШ-ийн 2020.04.09, №21, Ховд аймгийн ЭИХДЗШШ-ийн 2020.01.26, №2 магадлал.

А. Хаалттай хуралдаанаар хянан шийдвэрлэсэн магадлалыг цахим санд нийтлэхэд гаргасан алдаа зөрчил

Бэлгийн эрх чөлөөний эсрэг магадлалын тухайд цахим санд бодитоор 66 магадлал байршуулсан байсны хүрээнд алдаа, зөрчлийг авч үзье. Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дийлэнх тохиолдолд хаалттай шүүх хуралдаанаар хянан хэлэлцэгдсэн байх боловч ердөө нэг магадлалыг зөвхөн тогтоох хэсгийг нийтлэх байдлаар журмын дагуу санд байршуулжээ. Удиртгал болон тодорхойлох хэсгийг хамруулан, тогтоох хэсэггүй нийтлэгдсэн магадлал хоёр байна. Нийтлэгдсэн 66 магадлалын тухайд 40 тохиолдолд нь хаалттай хянан шийдвэрлэж буйг магадлалдаа тэмдэглэсэн байв. Гэсэн хэдий ч үүний 39 тохиолдолд удиртгал, тодорхойлох хэсэг, тогтоох хэсгийг бүхэлд нь хамруулан бүрэн эхээр нь байршуулжээ. Нэг л магадлал журамд заасны дагуу хаалттайгаар хянан хэлэлцэгдэж, зөвхөн тогтоох хэсгийг нийтэлжээ. Найман магадлалд нээлттэй хэлэлцэхээр тэмдэглэсэн бол 18 магадлалд энэ талаар огт дурдаагүй байна. Хууль, холбогдох журмаар хаалттай, нээлттэй хэлэлцэх эсэхийг шүүхийн шийдвэрт заавал тусгахыг үүрэг болгодоггүй тул үүнийг алдаа зөрчилд тооцоогүй болно.

Харин авлигын гэмт хэргийн магадлалд²⁸ тэмдэглэснээр нэг хэргийг хаалттай шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн атлаа шийдвэрийг цахим санд бүрэн эхээр нь нээлттэй байршуулсан байв. Нээлттэй шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн хэргийн 61 магадлалын 60 нь бүрэн эхээр, нэг магадлалын тогтоох хэсгийг оруулахгүйгээр хэсэгчлэн байршуулсан байна. Тодруулбал, давж заалдах шатны шүүхээс авлигын эсрэг гэмт хэргийг хаалттай хянан шийдвэрлэсэн нэг, нээлттэй шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн нэг, нийт хоёр магадлалыг цахим санд байршуулах явцад алдаа зөрчил гаргасан байна.

Б. Нууцлалыг хангах хүрээнд гарч буй алдаа зөрчил

Цахим санд нийтлэгдсэн бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн магадлалын тухайд хувь хүний мэдээллийн нууцлалыг алдагдуулсан байдлыг шүүгдэгч, хохирогч, гэрчийн хүрээнд харуулав.

²⁸ Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020.05.21, №644.

Хүснэгт 14. Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчдын мэдээллийн нууцлал хангагдсан байдал

№	Бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг	Нийт магадлал		Нууцлаагүй		
		тоо	хувь	тоо	хувь	
1	Нэр, овог	66	100	Шүүгдэгч	21	31.8
	Хохирогч			31	47.0	
	Гэрч			32	48.5	
2	Хувь хүн, байгууллагын регистрийн нууцлал	66	100	16	24.5	
3	Хувь хүн, байгууллагын хаягийн нууцлал	66	100	27	40.9	

Шүүгдэгчийн нэрийг нууцлаагүй 21 тохиолдлын гуравт нь шүүгдэгчийн нэрийг огт нууцлалгүй байршуулсан бол 17 магадлалд шүүгдэгчийн нэрийг үсгээр тэмдэглэн нууцалсан боловч магадлалын зарим хэсэгт нэрийг бүрэн бичиж байршуулсан хайхрамжгүй алдаа гаргажээ.

Хохирогчийн нэрийг ил байршуулсан 31 тохиолдлын долоод нэрийг нь үсгээр тэмдэглэн нууцалсан боловч зарим хэсэгт бүрэн бичсэн хайхрамжгүй алдаа гаргасан бол 24 тохиолдолд огт нууцлал хийгээгүй байв. Шүүгдэгчийн нэр, бусад мэдээллийг нууцлах хандлага хохирогчийнхоос өндөр хувьтай байна. Гэвч шүүхийн шийдвэр, магадлалын хүрээнд хохирогчийн эрүүл мэндийн нууц мэдээлэл нээлттэй мэдээлэгдсэн байв.

Хувь хүний регистрийн дугаар ил байршуулсан 16 магадлал байгаа бол хувь хүний гэрийн хаяг байршуулсан 39 тохиолдол нь бүгд шүүгдэгчийн регистрийн дугаар болон болон хаяг байна. Эдгээрээс 34 магадлал буюу бараг 50 хувьд нь гэрчийн нэрийг нууцлалгүй байршуулжээ.

Ийнхүү зохих нууцлалыг хийж цахим санд зөв байршуулсан магадлал 17 байгаа бол энэхүү шаардлагыг хангаагүй буюу хувь хүний нууцлалыг алдагдуулсан магадлал 49 буюу 74 хувьтай байна.

Цахим санд нийтлэгдсэн авлигын гэмт хэргийн 62 магадлалын тухайд шүүгдэгч, хохирогч, гэрчийн хувийн мэдээллийн нууцлал хэрхэн хангагдсан байдлыг Хүснэгт 15-д нэгтгэн харуулав.

Хүснэгт 15. Хэргийн болон шүүх хуралдаанд оролцогчдын мэдээллийн нууцлал хангагдсан байдал

№	Авлигын гэмт хэрэг	Нийт магадлал		Нууцлаагүй		
		тоо	хувь	тоо	хувь	
1	Нэр, овог	Шүүгдэгч	62	100	15	24.2
		Хохирогч	62	100	-	-
		Гэрч	62	100	45	72.9
2	Хувь хүн, байгууллагын регистр	62	100	11	17.8	
3	Хувь хүн, байгууллагын хаяг	62	100	12	19.4	

Шүүгдэгчийн нэрийг нууцлаагүй 15 тохиолдлын дөрөвт нь нэрийг огт нууцлалгүй байршуулсан бол 11 магадлалд шүүгдэгчийн нэрийг үсгээр тэмдэглэн нууцалсан боловч магадлалын зарим хэсэгт нууцлалыг алдагдуулсан хайхрамжгүй алдаа гаргасан байв. Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журмын дагуу нууцлах шаардлагатай мэдээллийн төрлүүдээс шүүгдэгчийн нэр, хаяг, хувь хүний регистрийн дугаарын нууцлалыг хангасан байдал 80 орчим хувьтай байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт боллоо. Харин гэрч, хохирогчийн мэдээллийг нууцлах асуудалд шүүхийн ажилтнууд онц ач холбогдол өгдөггүйг дээрх хүснэгтээс харж болохоор байна.

В. Бусад формал алдаа зөрчил

Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн магадлалын хүрээнд ноцтой алдаа дутагдал илрээгүй бөгөөд Баян-Өлгий аймгийн ДЗШШ-ийн

магадлалуудад шүүгдэгчийн биеийн байцаалт хэсгийг орхиж бичсэн тохиолдол дөрөв байсан нь бусад шүүхийн магадлалын стандарт бичилтээс өөр байв.

Авлигын гэмт хэргийн магадлалд шүүгдэгчийн биеийн байцаалт хэсгийг орхигдуулсан тохиолдол тав байгаа нь шүүгдэгчийн мэдээллийг нууцлах нэгдсэн арга зүй байхгүй байгааг харуулна. Магадлалд²⁹ бичигдсэн өмнөх шатны холбогдох шийтгэх тогтоолын огноо нь цахим санд нийтлэгдсэн тухайн шийтгэх тогтоолын огнооноос өөр тохиолдол нэг, Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлалд³⁰ холбогдох шийтгэх тогтоолыг гаргасан шүүхийн нэрийг цэгээр тэмдэглэх байдлаар нууцлах ёсгүй мэдээллийг нууцалсан нэг тохиолдол тус тус байв.

Г. Холбогдох шүүхийн шийдвэр нь цахим санд байршсан эсэх асуудал

Бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн 66 магадлалын 35-д холбогдох анхан шатны шүүхийн шийдвэр цахим санд байршсан бол 14 нь байршаагүй байна. 17 магадлалд шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хянан хэлэлцсэн байх бөгөөд одоогоор шүүхийн энэ төрлийн шийдвэр, баримт бичгийг цахим санд байршуулж эхлээгүй байна. Авлигын гэмт хэргийн 62 магадлалын 28-ынх нь холбогдох анхан шатны шүүхийн шийдвэр цахим санд байршсан бол 12-ынх нь байршаагүй байна. 21 магадлал нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хянан хэлэлцсэн байна.

3.3. ХЯНАЛТЫН ШАТНЫ ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Монгол Улсын хэмжээнд хяналтын шатны шүүхээс гэмт хэргийн төрөл тус бүрээр шийдвэрлэсэн хэргийн талаар албан ёсны статистикийн тоон мэдээлэл авах мэдээллийн нээлттэй эх сурвалж байхгүй байгаа болно. Ийм учраас цахим санд нийтлэгдсэн УДШ-ийн тогтоолын тоо бүрэн эсэхэд үнэлэлт өгөх боломжгүй байна.

²⁹ Увс аймгийн эрүү, иргэний хэргийн ДЗШШ-ийн 2020.1.31, №10 магадлал.

³⁰ 2020.1.16, №81 магадлал.

Хяналтын шатны шүүхээс бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн 41 тогтоол цахим санд байршсан байна. Үүнээс 26 тогтоолыг бүхэлд нь нууцалж, 15-ыг нь санд байршуулжээ. Эдгээр 15 хэргийг хаалттай шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн байх боловч 14 тогтоолын зөвхөн тогтоох хэсгийг нийтэлж, нэг тогтоолыг бүрэн эхээр нь санд байршуулсан байна. Харин УДШ-ээс авлигын гэмт хэрэг хянан шийдвэрлэсэн 20 тогтоол байршуулсан бөгөөд тэдгээрийг нээлттэй шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн тул тогтоол бүрийг бүрэн эхээр нь алдаа зөрчилгүй байршуулжээ.

Хяналтын шатны шүүхээс авлигын гэмт хэргийн тогтоолыг цахим санд байршуулахдаа шүүгдэгчийн нэр, овгийг үсгээр тэмдэглэсэн боловч тогтоолын зарим хэсэгт нууцлалыг алдагдуулсан гурван тохиолдол байна. Хувь хүний регистрийн дугаарын нууцлал 100 хувь хангагдсан, харин хаягийн нууцлал алдагдсан хоёр тохиолдол байна.

Шүүхийн шийдвэрийн цахим санд байршсан Эрүүгийн хуулийн 12, 22 дугаар бүлэгт тодорхойлсон гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн тогтоолын хүрээнд формал алдаа зөрчил гараагүй болно.

УДШ-ээс хянан шийдвэрлэсэн авлигын гэмт хэргийн 20 тогтоолд холбогдох анхан шатны шүүхийн 15 шийтгэх тогтоол санд байршсан бөгөөд таван шийтгэх тогтоолыг байршуулаагүй байна. Харин давж заалдах шатны шүүхийн 16 магадлал санд байршсан бол дөрвөн магадлалыг байршуулаагүй байна.

УДШ-ээс хянан шийдвэрлэсэн бэлгийн эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн 15 тогтоолд холбогдох анхан шатны шүүхийн есөн шийтгэх тогтоол санд байршсан бол таван шийтгэх тогтоолыг байршуулаагүй байна. Нэг шийтгэх тогтоолын мэдээлэл хяналтын шатны шүүхийн тогтоолд огт тусгагдаагүй тул санд байршсан эсэхийг шалгах боломжгүй байв. Харин давж заалдах шатны шүүхийн 13 магадлалыг санд байршуулсан бол нэг магадлалыг байршуулаагүй, нэг магадлалын мэдээллийг хяналтын шатны шүүхийн тогтоолд огт тусгаагүй тул санд байршсан эсэхийг шалгах боломжгүй байна.

ДӨРӨВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЦАХИМ САН ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn цахим хуудсыг системийн бүтцээс харахад мэдээллийг дараах төрөл, хэлбэрээр хайж олохоор хэрэглээнд нэвтрүүлжээ. Үүнд:

Хайлтын талбар:

- I. хэргийн төрлөөр (эрүү, иргэн, захиргаа, зөрчил);
- II. шүүхийн тогтолцоогоор (анхан, давж заалдах, хяналтын);
- III. шүүхээр (шүүх байгуулах тухай хуульд заасан шүүхийн нэршлээр);
- IV. шүүгчээр (шүүх бүрд ажиллаж байгаа шүүгчийн нэрээр);
- V. огноогоор (жил, сар, өдрөөр);
- VI. хэргийн дугаараар³¹;
- VII. түлхүүр үгээр;
- VIII. хүчинтэй эсэхээр.

I. Хэргийн төрлөөс хамаарсан үзүүлэлт нь энэхүү судалгааны ажлын хүрээнд дараах төрөлтэй байна. Үүнд:

- Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр;
- Шийдвэрийн дугаараар (ШЦТ гэсэн үсгэн тэмдэглэгээ орсон дугаартай шийтгэх, цагаатгах тогтоолууд нийтлэгддэг).

³¹ Хэргийн дугаар гэдэг нь прокурорын байгууллагаас олгосон дугаар тул шүүх дэх хэргийн индексээс тусдаа ойлголт юм. Эрүүгийн хэрэг болон бусад хэргийн хувьд хавтаст хэрэгт хэргийн дугаар бичигддэг. Энэ нь өмнө дурдсан ойлголтуудад хамаархгүй, хэргийг архивд шилжүүлэн өгөхтэй холбоотой дугаар байдаг.

Сайтын хувьд хэрэглэгч дээр дурдсан олон төрлийн мэдээлэл авах боломжтой байгаа хэдий ч шүүхийн шийдвэрийг нийтэлдэг сан гэдэг утгаараа шийдвэртэй холбоотой цогц мэдээлэл авах хүсэлтэй байдаг. Ер нь шүүхийн шийдвэрийг ийнхүү нийтэлж байгаа нь хэргийн оролцогч талуудад мэдээлэл өгөхөөс илүү тухайн шийдвэрийг олон нийтийн хяналтад хүргэх, судалгааны эргэлтэд оруулах, шүүхийн шийдвэрийн шүүмж судлалыг хөгжүүлэх, шүүхийн нээлттэй, ил тод байдлыг илтгэх зэрэгт чиглэдэг.

Харин хэргийн оролцогч буюу талууд хэрэг нь хэрхэн шийдвэрлэгдсэн, ямар шийд гарсныг сонирхох, түүнийг хүлээн зөвшөөрөх эсэх, эс зөвшөөрвөл давж заалдах, хяналтын гомдол гаргах, түүнийг нь шийдвэрлэсэн дээд шатны шүүхийн шийдвэр буюу хэргийг эцэслэн ямар шийд гарсан нь чухал бол сургалт, судалгаа, бусад чиглэлд сонирхсон сэдвийн хүрээнд хэд хэчнээн шийдвэр гарсан, шийд нь ямар байв, эцсийн шийдэл яаж гарсныг л хамгийн түрүүнд мэдэхийг эрмэлздэг.

Энэ талаас нь харвал хэрэглэгчийн төрлөөс үл хамааран тухайн нэг хэргийн шийдвэрлэлтийн эцсийн шийдлийн талаарх мэдээлэл нь хамгийн чухал гэж дүгнэж болох юм. Тэгвэл цахим санд үзүүлэлтээр нь дараах мэдээллийг нэмж оруулбал сангийн судалгааны ач холбогдол нэмэгдэж, мэдээллийн үзүүлэлт баяжихаар байна. Үүнд:

- Холбоотой бусад бүх шийдвэрийг нэг дор харуулах;
- Нийслэлийн давж заалдах шатны шүүхийг сонгоход түүний магадлал аль дүүргийн тогтоолыг хянасан болох нь мөн сонголтоор тус тусдаа үзүүлэлтээр харагддаг байх (хяналтын шатанд мөн хамаатай);
- Давж заалдах болон хяналтын шатны шүүхийг сонгоход холбоотой шийдвэрүүд нь шийдлийн төрлөөрөө харагддаг байх.

Шийдлийн төрөл гэдгээр шүүхийн шийдвэрийн тогтвортой байдлыг илэрхийлэх “хэвээр”, “өөрчлөлт”, “хүчингүй болсон” төрлүүдийг, мөн эдгээрийг дотор нь хуульд заасан үндэслэлээр нь задалсан үзүүлэлтийг хамааруулан илэрхийллээ.

Санд байршуулж буй мэдээлэл нь бидний судалгааны хувьд шийдвэрлэсэн эрүүгийн хэрэгт хамаарах шийтгэх, цагаатгах тогтоолыг нийтэлж байгаа гэдэг утгаараа шүүхийн статистик мэдээллийн үзүүлэлттэй давхцах, дүн нь хоорондоо тулах нь дамжиггүй юм. Иймд аливаа хэрэглэгчийн зүгээс хэргийн хөдөлгөөн, шүүхийн статистик, цахим санд байршуулсан шийдвэрийн мэдээллийг уялдуулан ашиглах, тулгах, үр дүнг үнэлэх, дүгнэх, судалгаанд энэ чиглэлээр ашиглаж хэвших нь эргээд системийн хөгжүүлэлтэд чухал нөлөөтэй юм.

Б. Хайлт, түүний илэрц

Цахим сангаас мэдээлэл хайхад харуулах бүтэц нь хайлт, шийдвэрийн жагсаалт гэсэн хоёр хэсгээс бүрдэж байна.

Хайлтын хэсэг:

Энэ хэсэг нь хайлт хийх үзүүлэлтийг агуулсан талбаруудаас бүрдэх бөгөөд судалгааны явцад талбаруудын хэвийн ажиллагаа, түүний илэрцийн хүрээнд дараах алдаа дутагдал ажиглагдлаа.

Хайлт нь дарааллын хувьд эхлээд заавал “огноо” талбарт мэдээллээ оруулах **хатуу нөхцөл** шаардаж байна. Энэ шаардлагыг хангаагүй тохиолдолд бусад талбарт мэдээлэл сонгох алхмыг дахин эхнээс нь хийх, энэ үед дахин дахин хугацаа зарцуулах, ачаалах хүндрэлүүд үүсэж байна.

“Шүүхийн нэр” талбарт Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийг сонгоод “Багануур” гэсэн түлхүүр үг оруулахад **түлхүүр үгээр оруулсан утгын хайлт хийгдэхгүй** нийслэлийн шүүхийн бүх магадлал илэрцээр гарч ирж байна.

“Зүйл хэсэг” талбарт сонголтоор байгаа **зарим зүйл, хэсгийн дугаар дараалаагүй, зүйл хэсэгт ямар ч хамааралгүй текстэн мэдээлэл**³² дунд нь **холилдсон**, 6.2, 6.3, 6.4 гэх зүйл, хэсэг нь эрүүгийн хуулийн ерөнхий ангийн зүйл, хэсэг орж ирсэн, эдгээрийг дангаар нь хайлт хийхэд холбогдох зүйлд хамаарах мэдээлэл илэрцээр гарч ирэхгүй, харин өөр зүйл, хэсэгтэй хослуулан хайхад өөр зүйл, хэсэгт л хамаарах

³² Алдааны утгыг Зураг 1-ээс харна уу.

мэдээлэл гарч ирж байна. Иймд 6.2-6.4 гэсэн зүйл, хэсэг шаардлагатай эсэх, шаардлагатай бол сонголт хийх хэсэг нь ажиллаж байгаа эсэхийг нягтлах шаардлагатай байна.

“Шийдвэрийн дугаар” буюу уг талбарын тухайд хэргийн дугаар гэсэн нэршлээс харвал эрүүгийн хэргийн дугаараар хайхаар хийгдсэн гэж ойлгогдож байна. Тухайлбал, 02 дугаар дээр алдаа гарч байгаа бөгөөд илэрцээр огнооны 02 дугаарыг ч мөн хайн, 2020 оны бүх шийдвэрийг харуулж³³ байна.

Шийдвэрийн жагсаалт хэсэг:

Хайлт хэсгийн талбараас сонгосон эсвэл гараас оруулсан утгын илэрц, үр дүнг харуулах хэсэг нь шийдвэрийн жагсаалтын хэсэг юм.

Энэ хэсэг нь мэдээллээ мөр, баганын дагуу харуулж байна. Ингэхдээ мөрийн урт болон хуудасны тоогоор нийт жагсаалтын урт тодорхойлогдож байгаа бол баганын утгуудаар мэдээллээ нарийвчлан харуулдаг байна.

“Шүүхийн нэр” баганын хажуугийн сум **шүүхийн нэрээ эрэмбэлэн харуулж чадахгүй**³⁴ байна.

“Огноо” баганын хажуугийн сум **огноог хуучнаас шинэ рүү эсвэл шинээс хуучин руу эрэмбэлэн харуулж чадахгүй** байна.

“Зүйл хэсэг” баганад **шүүхээс тогтоолыг нийтлэхдээ сонгосон зүйл, хэсгийн мэдээллийг** тухайн тогтоол руу орж үзэхээр “Хайлт” хэсгийн **“Зүйл хэсэг” талбарт бүрэн харуулж чадахгүй**³⁵ байна. Энэ алдаа нь тухайн талбарт мэдээлэл харуулах тэмдэгтийн хэмжээ бага өгөгдсөнтэй холбоотой байж болох юм.

³³ Энэ алдаа нь олон хэрэг шийдсэн шүүхийн хэмжээнд дугаар харгалзахгүй тохиолдож байна. Тухайлбал, 01-100 дугаар, мөн цаашлаад БЗД-ийн шүүхэд 2020 онд 2000 гаруй хэрэг шийдвэрлэгдсэн тул хоёр төдийгүй гурван оронтой тоо агуулсан дугааруудад дээрх алдаа тохиолдож байна. Ийм шалтгаанаар БЗД-ийн шүүхийн шийдвэрүүдийг цахим сангаас нэг бүрчлэн шүүхдээ шийдвэрийн дугаараар бус, зүйл хэсгээр нь шүүж судалгаанд дүгнэсэн. Харин бусад шүүхийн хувьд шийдвэрийн дугаар, огнооны дарааллыг баримтлан судалгааг гүйцэтгэсэн болно. Алдааны утгыг Зураг 2-оос харна уу.

³⁴ Алдааны утгыг Зураг 3-аас харна уу.

³⁵ Алдааны утгыг Зураг 4-өөс харна уу.

Зураг 2. Зүйл хэсэг талбарт өөр мэдээлэл сонголтоор оруулсан

Зүйл хэсэг	
	10.7.
Хэргийн дугаар	10.8.
	10.9.
Шийдвэрийн дугаар	10.10.
	10.11.
Хүчинтэй эсэх	10.12.
	festssssss
	10.6.2.

Зураг 3. Тухайлсан нэг хайлтын үр дүнг харуулж чадаагүй

Огноо ↑	Дугаар
2021-09-20	2021/ШЦТ/1010
2021-09-20	2021/ШЦТ/1011
2021-08-12	2021/ШЦТ/901
2021-07-08	2021/ШЦТ/801

Зураг 4. Шүүхийн нэрийн хажуугийн сум ажилладаггүй

Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2021-10-12
Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2021-10-08
Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	2021-10-08
Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүх	2021-10-08
Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2021-10-07

Зураг 5. Систем зүйл, хэсгийн мэдээллийг бүрэн харуулдаггүй

977	Төрбатын Шинэбаяр	27.10.2.1., 27.10.2.3.,
-----	-------------------	----------------------------

Шүүх	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх
Шүүгч	Төрбатын Шинэбаяр
Зүйл хэсэг	27.10.2.1.

В. Систем (сан) ашиглах талаар хэрэглэгчдэд зориулсан заавар

Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан нь нийтэд зориулсан мэдээлэл нийтэлж хүргэдэг. Иймд тус сангийн хэрэглэгчийн төрлийг судалгааны багийн зүгээс дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Системийн супер админ буюу үндсэн зохицуулагч;
- Санд мэдээлэл нийтлэн баяжуулж буй шүүх дэх хэрэглэгч;
- Сангаас мэдээлэл авч буй бусад хэрэглэгч.

Үндсэн зохицуулагч нь ШЕЗ дэх тодорхой албан тушаалтан байх бөгөөд системийн хэвийн ажиллагааг өдөр тутам хянан сайжруулах, хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх, шүүх дэх хэрэглэгчид арга зүйн заавар, чиглэл өгөх, сургах чиг үүрэгтэй гэж ойлгож байна.

Шүүхийн шийдвэрийн цахим сангийн хамгийн сүүлчийн хувилбарыг бид энэхүү судалгааны ажлын хүрээнд хэрэглэгчээр ашиглан судалсан билээ. Энэ сан нь сүүлд шинэчлэгдсэн шинэ тутам гэдэг утгаараа хэрэглэгчийн хувьд өмнөх сантай харьцуулан жиших, үнэлж дүгнэх явдал практикт нэлээд гарах болсон.

Хэрэглэгчдийн хувьд аливаа шинэ систем ашиглахдаа мэдээлэл хомс байдлаас үүдэлтэйгээр түүн дээр ажиллахаас төвөгшөөх, өмнө нь

ашиглаж сурсан хувилбарыг санагалзах нь элбэг тохиолддог. Ийм учраас шинээр зохиож байгаа болон өөрчлөлт оруулсан системийн хувьд хэрэглэгчийн онцлогтоо тохируулан сан ашиглах заавар, хүссэн хайлт, илэрцийн үр дүнд хэрхэн хүрэх алхам, үе шатыг мэдээлэх нь чухал юм.

Цахим сангийн хэрэглэгчдэд зориулсан энэ талын мэдээлэл, заавар шаардлагатай эсэх асуудал нь өмнө дурдсан системийн зарим талбарт хайлт хийх хатуу нөхцөл, мөн системийн алдаа дутагдал, энэхүү тайлангийн бусад хэсэгт дурдсан шүүхээс санд тогтоол байршуулах ажиллагаанд гарч буй нэгдсэн стандартгүй, арга зүйн зааварчилгаагүй ажиллаж буй байдлаас илхэн харагдаж байна.

Иймд хэрэглэгчдийн төрлөөс шалтгаалан тэдэнд зориулсан заавар, ажиллагааны үе шат, алхмыг тодорхой дурдсан мэдээлэл дутагдаж байгаа бөгөөд түүнийг боловсруулж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, нийтлэх болон ашиглах үйл ажиллагааг нэгдсэн стандартаар хэрэгжүүлэх боломжийг шүүхийн захиргааны байгууллагаас бүрдүүлж өгөх шаардлага тулгарч байна.

Шүүхийн шийдвэрийн цахим сан хэрэглэгчдийн дунд цахим асуулга явуулж тэдний санал хүсэлтийг авлаа. Shuukh.mn санг хэрэглэгчдийн 35.4 хувь нь хуульч байгаа бол 33.3 хувь нь эрх зүйч, 25 хувь нь оюутан, үлдсэн хувь нь багш, судлаач, бусад этгээд байна.

Эдгээр хэрэглэгчдийн 81 хувь нь тухайн тохиолдлыг шийдвэрлэсэн шүүхийн нийтлэг жишгийг харах зорилгоор хэрэглэдэг бол 64.6 хувь нь шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх зорилгоор, 47.9 хувь нь судалгаа шинжилгээний зорилгоор, 25 хувь нь шүүхийн шийдвэрийг бодлого боловсруулахад ашигладаг гэжээ.

Харин цахим сан хэрэглэхэд учирч буй хүндрэл, бэрхшээлийг багцлан дурдвал:

1. Монгол Улсын хэмжээнд шийдэгдсэн бүх хэргийн шүүхийн шийдвэр нийтлэгдэж байгаа гэдэгт эргэлздэг;
2. Хайлтын зүйл хэсэгт бичигдсэн утгаар илэрц гарч ирдэггүй;

3. Шүүхийн шийдвэр хугацаандаа нийтлэгддэггүй;
4. Тухайн шүүхийн шийдвэрийг үзээд буцах товч дарахад өмнө байсан хувилбартаа тохирдоггүй, бүх үйлдэл эхнээсээ эхэлдэг;
5. Хэргийн дугаар, шүүхийн нэр, шүүгчийн нэр зэрэг түлхүүр үгээр хайлтын илэрц олддоггүй;
6. Хугацаа маш удаан бөгөөд хэрэглэхэд ойлгомжгүй, төвөгтэй;
7. Тухайн хэргийн шийдвэртэй холбоотой бүх шатны шийдвэр гарч ирдэггүй гэх зэрэг хүндрэл, бэрхшээл дурджээ.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Шүүхийн тухай хуулийн 8.6-д заасан “Шүүх бүр өөрийн цахим хуудастай байж, шийдвэр, үйл ажиллагаагаа нийтэд тогтмол мэдээлж байна” гэсэн зарчим хэрэгжиж, шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах ажил тогтмол хийгдэж байна. Бидний судалгааны хүрээнд хамрагдсан шүүхүүдийн эрүүгийн хэргийн шүүхийн шийдвэр үндсэндээ шүүхийн цахим санд байршиж, олон нийтийн хяналт болон судалгааны эргэлтэд оржээ. Гэсэн хэдий ч зарим нэг анхаарах асуудал, дутагдал, хүндрэл байсаар байна. Тэдгээрийг доор багцлан оруулав.

Нэг. Шүүхийн шийдвэрийг хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн, хугацаанд нь бүрэн байршуулах

1. Шийтгэх тогтоолыг нийтлэхдээ нээлттэй хуралдааны шийдвэрийг цаг тухайд нь бүрэн нийтлэх, хаалттай хуралдааны тогтоолын хувьд журамд зааснаар зөвхөн тогтоох хэсгийг бүрэн нийтлэхэд анхаарах;
2. Хэргийн оролцогчийн нэрийн нууцлалын хувьд шүүгдэгчийн нэрээс гадна хохирогч, гэрчийн нэрийг нууцлах, нэг хэрэгт хэд хэдэн шүүгдэгч, хохирогч, гэрч, хууль ёсны төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч байгаа тохиолдолд тэдгээрийн нэрийг нууцлахдаа аль нэг нэрээр хязгаарлахгүй нууцлах, тогтоолын удиртгал хэсэгт дурдсан нэрсээр хязгаарлахгүй тодорхойлох, тогтоох хэсэгт дурдсан нэр, регистрийн дугаар зэрэг мэдээллийг нэг бүрчлэн шүүж нууцлах;
3. Шүүгдэгчийн овгийг нууцлалгүй, нэрийг нууцлах нь ялангуяа орон нутгийн хэмжээнд нэг нэгнээ сайн мэдэх нутаг дэвсгэрт шийдвэрлэсэн хэргийн хувьд ач холбогдолтой эсэхийг эргэн харах, шүүгдэгчийн овгийг нууцлах зохицуулалтыг журамд

тусгах, мөн шүүгдэгчийн овог, нэрийг нууцалсан ч хувийн бусад мэдээллийг нууцлахгүй байх нь мөн л орон нутгийн хэмжээнд нэг нэгнээ сайн мэдэх нутаг дэвсгэрт шийдвэрлэсэн хэргийн хувьд ач холбогдолтой эсэхийг эргэн харах;

4. Шүүгдэгчийн биеийн байцаалтад дурдсан овог, нэр, ам бүл, хөдөлмөр эрхлэлтийн байдал, нас, хүйс, гэр бүлийн байдал зэргийг хэрхэн нууцлах талаар нэгдсэн загвар гаргаж, бүх шүүхэд нэг стандартаар мөрдүүлж хэвшүүлэх;
5. Шүүгдэгчийн биеийн байцаалтын нэгдсэн загвар гаргахдаа цахим санд шийдвэр байршуулж байгаа зорилгод нийцүүлэн, тухайн шийдвэрийг судлах, хэрэглэгч сангийн мэдээллийг ашиглах нөхцөлийг харгалзах;
6. Гэр, орон сууцанд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн хувьд хаягийн мэдээллийг зөвхөн шүүгдэгчийн хаягийг нууцлах хэмжээгээр хязгаарлахгүй, хохирогч, гэрчийн мэдүүлэг зэрэгт хохирогчийн хаяг дурдагдсан эсэхийг нягтлах, шийдвэрт дурдсан тохиолдол бүрд нууцлах.

Хоёр. Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох

1. Цахим санд шүүхийн шийдвэрийг байршуулж буй дэд зохицуулагч буюу “админ”-ы эрхийг зөвхөн мэргэшүүлж сургасан албан хаагчид олгож хэвших;
2. Шийдвэрийг байршуулж буй албан хаагч үг, үсэг, дүрмийн алдаагүй байх шаардлага, мэдээлэл оруулахад тавигдах хэлбэрийн шаардлага болон агуулгын алдаа гаргах, нууцлалын талаар тавигдах шаардлагыг зөрчихөөс сэргийлсэн “санамж” гаргаж, мөрдүүлэх;
3. Шүүхийн Тамгын газар, шүүхийн захиргаа, хэргийн хөдөлгөөний хяналтыг хэрэгжүүлэх нэгжээс дээр дурдсан нууцлах ажиллагаа, алдаа дутагдал гаргахаас сэргийлэх ажилд

тогтмол хяналт тавьж хэвших, ялангуяа шүүхийн Тамгын газрын дарга нар цахим санд шүүхийн шийдвэр хэрхэн байршуулсныг тогтмол хянаж хэвших;

4. Захирамж, тогтоолоор шийдвэрлэсэн хэргийн шийдвэрийг цахим санд байршуулах асуудлаар нэгдсэн заавар, чиглэл гаргах, шийдвэр нийтлэх ажиллагаанд жигдрээгүй, нэгдсэн үйл ажиллагаа хэвшээгүй шүүхүүдэд мэргэжил, арга зүйн тусламж тогтмол үзүүлэх, нийтлэх ажиллагаанд гарч буй алдаа дутагдлыг байнга судлах.

Гурав. Цахим санг хэрэглэгчид ээлтэй болгох

1. Шат шатны шүүх хооронд хэд хэдэн удаа шийдвэрлэсэн хэргийн бүх шийдвэрийг “холбоотой шийдвэрүүд”-ээр нэг дор харуулах, зөв холбох;
2. Нийслэлийн давж заалдах шатны шүүх болон анхан шатны хэд хэдэн шүүхээс шийдвэрлэсэн тогтоолыг хянадаг давж заалдах шатны шүүхүүдийн магадлалыг сонгоход тухайн магадлал нь аль дүүргийн шүүхийн тогтоолыг хянасан төрлөөрөө хайгддаг байх;
3. Давж заалдах болон хяналтын шатны шүүхийг сонгоход холбоотой шийдвэрүүд нь шийдлийн төрөл (хэвээр, өөрчлөлт, хүчингүй, дахин хэлэлцүүлэхээр буцаасан, хэрэгсэхгүй болгосон, цагаатгасан гэх мэт, хүчингүй болгосон, өөрчилсөн зэрэг шийдвэр нь шийдвэрийн төрлөөр)-өөрөө хайгддаг, судлагдах боломжтой байх;
4. Хайлт хэсэг дэх “шийдвэрийн дугаар”, мөн “түлхүүр үг” талбаруудад хайлтын үр дүнг оновчтой болгох, тухайлбал:
 - Хэд хэдэн өгүүлбэр эсхүл текстийн эх бичвэр оруулж, түүнтэй утга, агуулгын хувьд ижил хэргийн шүүхийн шийдвэр хайх;
 - Түлхүүр үг ашиглан хэргийн шүүхийн шийдвэр хайх;

- Хэрэглэгч дан ганц текст оруулж хайлт хийх биш, хайх утгыг зурган файл хэлбэрээр оруулах боломжтой болгох;
- 5. “Шийдвэрийн жагсаалт” хэсэг дэх мэдээллийг эрэмбэлэн харуулах сумыг ажилладаг болгох;
- 6. Шүүхээс шийдвэр нийтлэхдээ хэд хэдэн зүйл, хэсэг сонгосон тохиолдолд зүйл, хэсгүүдийг зэрэгцүүлэн “Зүйл хэсэг” талбарт бүрэн харуулах;
- 7. shuuh.mn сангийн шинэ хувилбарыг хэрхэн хэрэглэх, талбаруудад мэдээллийг хэрхэн бүртгэх, сонгох талаар зааварчлах, хайлт, түүний үр дүнд нөлөөлж буй хатуу нөхцөл бүхий ажиллагааны алхмуудыг тайлбарласан заавар боловсруулах, санд байршуулах.

Дөрөв. Эрх зүйн орчныг боловсронгуй болгох

ШЕЗ-ийн 2014 оны 32 тоот тогтоолоор баталсан “Шүүхийн шийдвэрийг нийтлэх журам” болон ШЕЗ-ийн ажлын албаны даргын 2017 оны А/44 дүгээр тушаалаар баталсан “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”-ыг нэгтгэн боловсруулж мөрдүүлэх нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Монгол Улсын Шүүхийн тухай хууль, 2021.
3. Эрүүгийн хууль, 2015.
4. ШЕЗ-ийн Гүйцэтгэх нарийн бичгийн даргын 2017 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А/44 тоот тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэрийг цахим санд байршуулах журам”.
5. “Шүүхийн шийдвэрийг нийтлэх журам”, ШЕЗ-ийн 2014 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 32 тоот тогтоол.
6. Монгол Улсын шүүхийн сонгомол шийдвэрийн эмхэтгэл, I боть. 2015.
7. ШЕЗ, Шүүн таслах ажиллагааны тайлан, 2020.
8. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс 2021 оны 9 дүгээр сарын 28-ны өдрийн 01/849 тоот албан бичгээр ирүүлсэн тайлан.
9. Шүүхийн шийдвэрийн цахим сан буюу shuukh.mn

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Бэлгийн эрх чөлөөний халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шийдвэрийг цахим санд байршуулсныг шүүн таслах ажиллагааны тайлангийн холбогдох утгатай харьцуулсан үзүүлэлт

№	Шүүх	Шүүн таслах ажиллагааны мэдээ	www.shuukh.mn-д нийтлэгдсэн ТОГТООЛ	Судлагдсан ТОГТООЛ
1	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	50	35	35
2	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	18	10	10
3	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	17	15	15
4	Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	8	11	12
5	Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	17	15	15
6	Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	26	29	29

Хавсралт 1-ийн үргэлжлэл

7	Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	5	2	2
8	Налайх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	5	2	2
9	Багахангай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	0	0
10	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	6	4	2
11	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	3	4	1
12	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	35	21	4
13	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	10	11	2
14	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	3	3	1
15	Говьсүмбэр дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	4	4	1

Хавсралт 1-ийн үргэлжлэл

16	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	9	3	3
17	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	7	2	1
18	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	13	13	2
19	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	6	4	1
20	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	0	0
21	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14	7	1
22	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	8	0	0
23	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	6	2	1

Хавсралт 1-ийн үргэлжлэл

24	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14	7	1
25	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	8	3	1
26	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	7	1	1
27	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	16	10	1
28	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	9	5	1
29	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	6	5	1
30	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	8	6	1
31	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	6	6	1

Хавсралт 1-ийн үргэлжлэл

32	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	3	1	1
33	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	2	2	1
34	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	2	3	1
35	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	9	6	1
36	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	4	4	1
37	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	3	0	0
38	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	0	0	0
	Нийт	369	256	153

*Хавсралт 2. Авлигын гэмт хэргийн шийдвэрийг цахим санд
байршуулсан тоон мэдээг шүүн таслах ажиллагааны
статистик мэдээлэлтэй харьцуулсан байдал*

№	Шүүх	Шүүн таслах ажиллагааны мэдээ	www.shuukh.mn-д нийтлэгдсэн тогтоол
1	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14	8
2	Сүхбаатар дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	21	20
3	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	14	6
4	Баянгол дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	5	6
5	Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	6	5
6	Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	3	3
7	Багануур дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	0
8	Налайх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	0

Хавсралт 2-ын үргэлжлэл

9	Багахангай дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	0
10	Архангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	1
11	Баян-Өлгий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	11	10
12	Баянхонгор аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	0
13	Булган аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	2
14	Говь-Алтай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	4	4
15	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	0
16	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	1

Хавсралт 2-ын үргэлжлэл

17	Дорноговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	0
18	Дорнод аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	1
19	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	1
20	Завхан аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	0
21	Орхон аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	0
22	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	0
23	Өмнөговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	0
24	Сүхбаатар аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	0

Хавсралт 2-ын үргэлжлэл

25	Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	1
26	Төв аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	4	2
27	Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	3	2
28	Ховд аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	1	0
29	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2	2
30	Хэнтий аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	0
31	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	0	0
32	Завхан аймгийн Тосонцэнгэл сум дахь сум дундын шүүх	0	0

Хавсралт 2-ын үргэлжлэл

33	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүх	4	4
34	Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь сум дундын шүүх	1	0
35	Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүх	0	0
36	Сэлэнгэ аймгийн Сайхан сум дахь сум дундын шүүх	1	0
37	Ховд аймгийн Булган сум дахь сум дундын шүүх	3	2
38	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дахь сум дундын шүүх	2	1
39	Нийт	116	82

Хавсралт 3. Шүүхийн шийдвэрийн цахим санд бэлгийн эрх чөлөөний халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн шүүхийн шийдвэрийг байршуулах явцад гарсан алдаа зөрчил

№	Алдаа дутагдал	Шийтгэх тогтоолын дугаар, тайлбар
1	Нийтлэгдээгүй	113 шийтгэх/цагаатгах тогтоол нийтлэгдээгүй бөгөөд шүүх тус бүрээс нийт шийдвэрийн хүрээнд бус, тодорхой төрлийн хэргийн шийдвэрт мониторинг хийсэн тул дугаарлалтын дарааллаар нийтлээгүй шийтгэх тогтоолыг олж тогтоох боломжгүй байв.
2	Хоёр удаа буюу давтан нийтлэгдсэн	БЗД-ийн ЭХАШШ-ийн 27-р, СХД-ийн ЭХАШШ-ийн 16-р, БГД-ийн ЭХАШШ-ийн 8-р шийтгэх тогтоол тус бүр хоёр удаа нийтлэгдсэн. СБД-ийн ЭХАШШ-ийн 219, 692-р тогтоолууд нэг хэргийн тогтоол байх бөгөөд хэргийн индекс өөрчлөгдсөн, огнооны дарааллаар зүйлчлэл хүндэрсэн байдлаас харвал дээд шатны шүүхээс анхан шатны шүүхэд буцаагдаж дахин шийдвэрлэсэн байх талтай. Ийм учир алдаа зөрчилд тооцоогүй.
3	Зүйл хэсгийн хайлтын автомат илэрцэд гарч ирээгүй	2020 оны 1 дүгээр сард Эрүүгийн хуульд орсон нэмэлтээр 12.6-д шинэ төрлийн гэмт хэргийг тодорхойлсон ба энэ нь хайлтын хэсэгт автомат сонголтоор гарч ирдэггүй. Гараар бичиж оруулахад улсын хэмжээнд нэг буюу БГД-ийн ЭХАШШ-д шийдвэрлэгдсэн байв.
4	Шийтгэх тогтоолыг бүхэлд нь нууцалсан	БЗД-ийн ЭХАШШ-ийн 18, СХД-ийн ЭХАШШ-ийн 831-р шийтгэх тогтоолын хуудсанд нэвтрэхэд “Шийтгэх тогтоол нууцлагдсан тул тухайн ШТГ-тай холбогдоно уу” гэсэн бичиг гарч ирдэг. Шийтгэх тогтоолыг ийнхүү бүхэлд нь нууцлах эрх зүйн зохицуулалт байхгүй.
5	12-р бүлэгт заасан гэмт хэрэг биш буюу андуурч нийтлэгдсэн	БЗД-ийн ЭХАШШ-ийн 505-р шийтгэх тогтоол нь Эрүүгийн хуулийн 13-р бүлэгт заасан гэмт хэргийг хянан шийдвэрлэсэн байх бөгөөд зүйл, хэсгийг 12.5.1 гэж буруу оруулсан байна.

Хавсралт 4. Авлигын гэмт хэргийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулах явцад гарсан алдаа зөрчил

№	Алдаа дутагдал	Шийтгэх тогтоолын дугаар, тайлбар
1	Нийтлэгдээгүй	34 шийтгэх/цагаатгах тогтоол нийтлэгдээгүй бөгөөд шүүх тус бүрээс нийт шийдвэрийн хүрээнд бус, тодорхой төрлийн хэргийн шийдвэрт мониторинг хийсэн тул дугаарлалтын дарааллаар нийтлээгүй шийтгэх тогтоолыг олж тогтоох боломжгүй байв.
2	Шийтгэх тогтоолыг бүхэлд нь нууцалсан	БГД-ийн ЭХАШШ-ийн 2020.06.29-ний өдрийн №640, БГД-ийн ЭХАШШ-ийн 2020.06.09-ний №574, 2020.07.09-ний №679, ХУД-ийн ЭХАШШ-ийн 2020.05.02-ны №319 шийтгэх тогтоол.
3	22-р бүлэгт заасан гэмт хэрэг биш буюу андуурч нийтлэгдсэн	БГД-ийн ЭХАШШ-ийн 2020.06.29-ний өдрийн №640.

